

**ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН  
2013 ОНЫ ЗОРИЛТЫН БИЕЛЭЛТ**

2013-11-29

Д/д	Үндсэн зорилтын №	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцах байгууллага, хэлтэс, алба	Биелэлт	Үр дүн, хувь
<b>Нэг. Дүүргийн эдийн засаг, санхүүгийн чадавхийг бэхжүүлнэ.</b>					
<b>1.1. Бизнес эрхлэгчдийг дэмжих талаар</b>					
1.	1.1.1	Жижиг дунд үйлдвэрлэл, бичил бизнес эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжидурт хугацаатай, бага хүүтэй зээл олгоход дэмжлэг үзүүлж холбогдох байгууллагад уламжлах	ХҮХ, ЖДҮДТ	2013 онд урт хугацаатай, бага хүүтэй зээлд хамрагдахаар 70 жижиг дунд үйлдвэрлэл, бичил бизнес эрхлэгч иргэд, аж ахуйн нэгж 3990.0 сая төгрөгийн төсөл ирүүлснээс төсөл сонгон шалгаруулах дүүргийн дэд комисс 15 иргэн, аж ахуйн нэгжийн 550.0 сая төгрөгийн төслийг шалгаруулан холбогдох санхүүгийн байгууллагад шилжүүлсэн. Банкны шаардлага хангаагүйгээс 4 төсөл нь хасагдаж, 11 иргэн, аж ахуйн нэгж нь 405.0 сая төгрөгийн зээлд хамрагдан төслөө хэрэгжүүлж байна. Дэд комиссын 2013 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар 5 төслийг хэлэлцэн 2 аж ахуйн нэгжийн 95.0 сая төгрөгийн төслийг шалгаруулан холбогдох санхүүгийн байгууллагад уламжилсан. Дүүргийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй жижиг дунд үйлдвэрлэл эрхэлдэг, 100.0 сая төгрөгөөс дээш санхүүжилт шаардлагатай 9 ААНБ-ын ЖДҮ-ийн зээлд хамрагдах хүсэлтийг Хөдөлмөрийн яаманд уламжилсан.	100.0
2.		Жижиг дунд үйлдвэрийн зээлд хамрагдсан иргэд, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд мэргэжлийн байгууллагатай хамтран хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх	ХҮХ, ЖДҮДТ	2013 онд Жижиг дунд үйлдвэрийн хөнгөлттэй зээлд хамрагдан үйл ажиллагаагаа явуулж буй 11 иргэн, аж ахуйн нэгжийн зээлийн зориулалт, ашиглалтанд 2013 оны 8 дугаар сарын 1-6 өдрүүдэд хяналт шалгалтыг зохион байгуулахад иргэн, аж ахуйн нэгж нь зээлээ зориулалтын дагуу ашиглаж байсан бөгөөд холбогдох мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч ажилласан. Дүүргийн Засаг даргын 2013 оны 384 дүгээр захирамжийн дагуу 2011 онд жижиг дунд үйлдвэрлэлийн зээлд хамрагдсан 41 иргэн, аж ахуйн нэгж	100.0

				байгууллагуудын зээлийн ашиглалт, зарцуулалт болон эргэн төлөлтийн талаарх хяналт шалгалтыг 2013 оны 9 дүгээр сарын 26-аас 10 дугаар сарын 17-ний өдрүүдэд зохион байгуулсан. Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй 38 иргэн, аж ахуйн нэгж байгууллагаар шалгалтын комисс биечлэн орж, үйл ажиллагаатай нь танилцан холбогдох заавар зөвлөгөөг өгч, тэдний санал бодлыг сонссон. Газар тариалан, фермерийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 3 иргэний зээлийн эргэн төлөлтийн мэдээллийг холбогдох банк болон тухайн орон нутгийн Хөдөлмөрийн хэлтсээс гаргуулан авсан.	
3.		Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангахад дэмжлэг үзүүлэх	СТСХ, ЗХХ	Дүүргийн 2013 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай ИТХ-ын 5/1 дүгээр тогтоолоор шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах нэмэлт эх үүсвэр 18.0 сая төгрөгийг баталж өгсөн байна. Төвийн байр барих газрыг дүүргийн Засаг даргын 2013 оны 365 дугаар захирамжаар 18-р хорооны нутаг дэвсгэрт 0,025 га газрыг шийдвэрлэсэн.	100.0
4.	1.1.2	Бичил бизнес болон жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг сургалтанд хамруулах, холбогдох мэдээ мэдээллээр ханган, инкубатор төвийн бойжигчдын тоог нэмэгдүүлэх	ХҮХ, ЖДҮДТ	Дүүргийн Засаг даргын 2013 оны 55 дугаар захирамжаар ЖДҮДСМТ-ийг шинээр 11 хүний орон тоотой байгуулан, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг сургалт, мэдээ мэдээллээр хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 253 сүлжээний бойжигчдод дэмжлэг үзүүлэн ажилласан. Дүүргийн ЖДҮДСМТөвтэй хамтран (Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сургалт мэдээллийн төв) зохион байгуулсан бизнесийн сургалтанд давхардсан тоогоор 698 иргэн, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих “Сонгинохайрхан” төвийн бизнесийн сургалтанд давхардсан тоогоор 219 иргэнийг тус тус хамруулж, 1000 орчим иргэнд зөвлөгөө мэдээллийг өгч ажиллаа. Тус төвд 9 үйлдвэр бойжигч байгууллага жилийн 30.0 орчим сая төгрөгийн түрээсийн хөнгөлттэй нөхцөлөөр үйл ажиллагаа явуулж, нийт 33 хүнийг ажлын байраар ханган ажиллаж байна. Дүүргийн Засаг даргын 2013 оны 187 дугаар захирамжийн дагуу Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, Монголын Олон Улсын ба Үндэсний Арбитрын газартай хамтран шинээр бизнес эрхлэх болон бүтээлч үйл ажиллагааг дэмжих, бизнес эрхлэхээс өмнө болон бизнесийн үйл ажиллагааны явцад учирч болох эрсдлээс урьдчилан сэргийлэх сургалтыг 2013 оны 05 дугаар	100.0

				сарын 14, 15-ны өдрүүдэд 71 иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудыг хамруулан зохион байгууллаа. Дэлхийн зөн олон улсын байгууллагын Толгойт, Баянхошуу салбартай хамтран ажиллаж, мэргэжлийн сургалтанд 128, бизнес шат дараалсан сургалтанд 491 гаруй иргэнийг хамруулан, үйл ажиллагааг нь дэмжин ажиллаж байна.	
5.		Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийг бүртгэлжүүлэх	ХҮХ, ЖДҮДТ	Дүүргийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа эрхлэж буй жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн суурь судалгааг шинэчилсэн бөгөөд одоогоор хүнсний үйлдвэрлэл 86, барилгын материал үйлдвэрлэл 60, хөнгөн үйлдвэрлэл 28, гоо сайхны бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2, өлөн боловсруулах үйлдвэрлэл 11, сав баглаа боодлын үйлдвэрлэл 3, төмөр хийцийн үйлдвэрлэл 10, уул уурхайн үйлдвэрлэл 19, хими, ахуйн чиглэлийн үйлдвэрлэл 9, эм, эмэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 3, эсгий үйлдвэрлэл 4, архи, спирт үйлдвэрлэл 3, дахин боловсруулах үйлдвэр 2, бичил бизнес, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчид 1197 иргэн, аж ахуйн нэгжийг бүртгэлжүүлээд байна.	100.0
6.		21 дүгээр хороонд талх нарийн боовны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх хүсэлтэй иргэдийг төсөл боловсруулах сургалтанд хамруулан, санал санаачилгыг дэмжин ажиллах	ХҮХ	Талх, нарийн боовны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх хүсэлтэй 21 дүгээр хорооны 3 иргэнийг бүлэг болгон, дүүргийн ЖДҮДМСТ-ийн 2013 оны 09 дүгээр сарын 11-13-ны өдрийн “Бизнесээ эхэл, бизнесээ хөгжүүл” сэдэвт 3 хоногийн сургалтанд хамруулсан бөгөөд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн бичил зээлд хамрагдахаар Хөдөлмөрийн хэлтэст хандан, төсөл боловсруулж байна.	90.0
7.	1.1.3	Жаргалант тосгонд сүү, мах, өндөгний чиглэлийн эрчимжсэн аж ахуй бий болгоход дэмжлэг үзүүлэх	ХҮХ	ҮХААЯамнаас зарласан “Сүү үхэр, гахай тахиа, зөгийн аж ахуйг өргөтгөхөд дэмжлэг үзүүлэх” төсөлд оролцохоор хүсэлт гаргасан 17 иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг дэмжин уламжилсан. “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” хөтөлбөрийн хүрээнд Нийслэлийн үйлдвэр хөдөө аж ахуйн газрын Эрчимжсэн мал аж ахуйн хэлтэстэй хамтран Жаргалант тосгонд сүү, махны эрчимжсэн мал аж ахуйг бий болгох судалгааны ажил хийгдэж байна.	90.0
8.		Өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг зохион байгуулах	ХҮХ	Дүүргийн “Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн зөвлөгөөн”-ийг 2013 оны 05 дугаар сарын 09-ний өдөр төрийн бус байгууллагуудтай хамтран Соёмбо кинотеатрт зохион байгуулсан. Тус арга хэмжээний үеэр өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн	100.0

			<p>үзэсгэлэнг зохион байгуулж, 214 хувиараа хөдөлмөр эрхлэгч болон аж ахуйн нэгж байгууллагуудыг оролцууллаа. 2013 оны 06 дугаар сарын 7-12 хооронд Мишээл экспо төвд зохион байгуулагдсан “Үйлдвэрийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологи 2013” олон улсын үзэсгэлэн худалдаанд дүүргийн Нэмүүртөгийн сүлжээ, Ховор угалз ХХК, Нью загал, Мандах говь сургалтын төв зэрэг иргэн, ААН оролцсон. Тус үзэсгэлэнд оролцсон ААНБ-ын дунд уралдаан зарлаж Мандах говь сургалтын төв шилдэг ажил олгогчоор шалгаран өргөмжлөл, цом, Нью загал сургалтын төв нь тусгай байранд тус тус шалгарч амжилттай оролцсон. Дэлхийн зөн олон улсын байгууллага, Технож бизнес инкубатор төв, дүүргийн нэмүүртөгийн сүлжээний орон тооны бус удирдах зөвлөл хамтран өрхийн болон жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үзэсгэлэн худалдааг 2013 оны 06 сарын 28-30-ны өдрүүдэд Улаанбаатар бизнес хөгжлийн төвд зохион байгууллаа. Дүүргийн өрхийн үйлдвэрлэл эрхлэгч 10 иргэн тус үзэсгэлэнд оролцов. 2013 оны 06 сарын 28-аас 07 дугаар сарын 2-ны өдрүүдэд хамтын ажиллагаатай дүүрэг болох ӨМӨЗО-ны Хөлөн буйр аймгийн Хайлаар хотод зохион байгуулагдсан олон улсын үзэсгэлэн худалдаанд Оюунлаг мандах говь ТББ, Нью загал сургалтын төв болон бүлгээр ажиллаж буй иргэдийн хамтаар амжилттай оролцсон. Нью загал сургалтын төвийн сургалтанд хамрагдаж чадамжийн гэрчилгээ авсан өрхийн үйлдвэрлэл эрхлэгч, болон бүлгээр ажиллаж буй 3 иргэн 2013 оны 08 дугаар 20-23-ны өдрүүдэд БНХАУ-ын Эрээн хотод зохион байгуулагдсан олон улсын үзэсгэлэнд оролцоод ирсэн. 2013 оны 09 дүгээр сарын 26-29-ний өдрүүдэд Дэлхийн зөн Монгол ОУБ-аас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Хамтдаа урагшлъя” үзэсгэлэн худалдаанд дүүргийн өрхийн бичил бизнес эрхлэгч 47 иргэдийг оролцуулж, бараа бүтээгдэхүүнээ худалдаалсан. 2013 оны 10 дугаар сарын 15-ны өдөр 9-р сургуулийн зааланд Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгээс зохион байгуулсан гэр хорооллын хэрэглэгчдэд зориулсан албан бус сургалтын үеэр Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч 6 иргэн, аж ахуйн нэгжүүдийн бараа бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг гаргасан. Үйлдвэр хөдөө аж ахуйн газар, Арьс шир, ноос ноолуурын холбоо,</p>	
--	--	--	---	--

			Мишээл экспо төв хамтран 2013 оны 10-р сарын 17-21-ний өдрүүдэд Мишээл экспо төвд зохион байгуулсан Арьс шир, ноос ноолууран бүтээгдэхүүн-2013 үзэсгэлэн худалдаанд дүүргийн 4 үйлдвэр, 3 өрхийн үйлдвэрлэл эрхлэгч иргэдийг оролцууллаа. Дүүргийн ноос, ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгч Уужин ХХК-ий "Меланж эмэгтэй нөмрөг" бүтээгдэхүүн нь "Сарлагийн хөөврөн шилдэг бүтээгдэхүүн"-ээр шалгарч ӨРГӨМЖЛӨЛ-өөр шагнагдсан.	
9.	Өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдэд санхүүгийн эх үүсвэр бий болгоход дэмжлэг үзүүлэх	ХҮХ	Нийслэлийн бичил бизнесийг дэмжих 1-6 сая төгрөгийн зээлд 21 жижиг бичил бизнес эрхлэгч 125,0 сая төгрөгийн зээл хүссэнээс 48,0 сая төгрөгний зээлд хамрагдан 47 хүнийг ажлын байраар ханган үйлдвэрлэлээ амжилттай эрхэлж байна. Нийслэлийн жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийн хөнгөлттэй зээлд хувцас засвар, оёдлын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй өрхийн үйлдвэрлэгч 2 иргэнийг тус бүр 6.0 сая төгрөгийн хөнгөлттэй зээлд хамруулсан. ЖДҮДС төвийн бойжигч 2 иргэнд 2,0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, түүхий эд материалын дэмжлэг, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зээлд хамрагдсан 2 бойжигчийн зээлийн хүүг төлөх зэргээр үйлдвэрлэл эрхлэгч нарыг дэмжин ажиллаж байна. Тус төвтэй хамтран ажилладаг 9 иргэн сарын 0,85 хувийн хүүтэй 42,0 сая төгрөгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зээлд хамрагдсан байна. Өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдэд санхүүгийн эх үүсвэрийг бий болгох үүднээс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн /иргэнд 5,0 хүртэл сая, ААНэгжид 10,0 хүртэл сая төгрөг/ зээлд 311,8 сая төгрөгийн 77 төслийг хэрэгжүүлэн 313 ажлын байрыг бий болгоод байна. Дэлхийн Зөн ОУБ, Зөн сан ББСБ-тай хамтран мэргэжлийн болон бизнесийн шат дараалсан сургалтанд хамрагдсан, дүүргийн өрхийн үйлдвэрлэл болон бичил бизнес эрхлэгч иргэдийн дунд төсөл шалгаруулах уралдаан зарлаж 23 төсөл хүлээн авч үүнээс 10 төслийг шалгаруулан 1,0 сая хүртэлх төгрөгийн 50 хувийг нь Дэлхийн Зөн ОУБ буцалтгүй тусламжаар, үлдсэн 50 хувийг нь Зөн сан ББСБ бизнесийн зээлд хамруулах зэрэг дүүргийн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих чиглэлээр төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж байна.	100.0

10.	1.1.4	Гадаадын хөрөнгө оруулагч нартай хамтран ажиллах боломжийг судлах	ХҮХ, ЗХХ	Мал аж ахуй, газар тариалангийн чиглэлээр хөрөнгө оруулах, хамтран ажиллах боломжийг судлан Хөдөлмөрийн яам, Үйлдвэр хөдөө аж ахуйн яам, Монголын үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхим зэрэг байгууллагуудтай холбогдсон. Үүний дагуу Үйлдвэр хөдөө аж ахуйн яамнаас зарласан “Сүүний чиглэлийн үхрийн 50-300 үнээний цогцолбор байгуулах” францын хөрөнгө оруулалттай төслийн шалгаруулалтанд шалгарсан дүүргийн 4 фермер эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийн холбогдох баримт бичгийг банк санхүүгийн байгууллагад шилжүүлсэн. Япон Улсын Жайка ОУБ-тай хамтран “Жаргалант” тосгонд 5 га газарт Япон сортын “Гүзээлзгэнэ” тариалах ажилд хамтран ажиллах болсон. 21-р хорооны 361-ын гарам орчмын 200 га газарт “Аж үйлдвэрийн парк” байгуулах ажил судалгааны түвшинд явагдаж байгаа ба Солонгосын Леадинг аллиансе ХХКомпанид хөрөнгө оруулагчаар хамтран ажиллах тухай хүсэлтийг 2013 оны 1/1187 тоот албан бичгээр хүргүүлсэн. Тус байгууллага хамтран ажиллахаа мэдэгдсэн.	90.0
11.	1.1.5	Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд газар олгох, өмнө нь дээрх зориулалтаар олгосон газрын ашиглалтанд дүн шинжилгээ хийх	ХҮХ, ӨГХА	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2012 оны 3/10 дугаар тогтоолд Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлагыг тодорхойлсон баримт бичгийг батлуулах хүртэл хугацаанд Нийслэлийн нутаг дэвсгэрт шинээр газар эзэмшүүлэх, ашиглуулах эрх олгохгүй байхыг Нийслэл, дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосон тул шинээр газар эзэмших эрх олгох боломжгүй байна. Өмнө нь тухайн зориулалтаар 21-р хороонд олгосон газрын ашиглалтанд Газрын тухай хуулийн 40.1.6 заалтын дагуу 2 жил дараалан газраа гэрээнд заасан зориулалтаар ашиглаагүй тохиолдолд хүчингүй болгох судалгаа гарган ажиллаж байна.	70.0
12.		Хүлэмж, Зоорь, Агро парк хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, дүүргийн агро парк түшиглэн ТББ-тай хамтарч сургалт зохион байгуулах	ХҮХ	“Шинэлэг санаан дээр суурилсан хүнсний аюулгүй байдлыг хангах” хөтөлбөрийн хүрээнд “Каритас-монгол” ТББ-аас 46 хүлэмж, 29 зоорийг барьж байгуулан дүүргийн нутаг дэвсгэрт төмс, хүнсний ногооны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа 75 иргэнд хүлээлгэн өгсөн. “Хүлэмжийг хэрхэн ашиглаж сурах, зоорийг яаж бий болгох, түүнийг ашиглах нь” сэдэвт сургалтыг Дэлхийн зөн олон улсын байгууллагатай хамтран Толгойт,	100.0

				Баянхошуу бүсийн 100 гаруй иргэдийг хамруулан зохион байгуулсан.	
13.		Тариаланчид, ногоочдын дүүргийн зөвлөгөөн, экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн үзэсгэлэн худалдааг зохион байгуулах	ХҮХ	“Намрын ногоон өдрүүд-2013” нэгдсэн арга хэмжээний хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт 5 цэгт павилон байршуулан хямд үнэ бүхий төмс, хүнсний ногоогоор ард иргэдэд 08-аас 10 дугаар сар хүртэл худалдааг зохион байгуулсан. Экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг “Намрын ногоон өдрүүд”-2013 арга хэмжээнд оролцуулан шилдэг Гран-при шагналыг Милко ХХК-ний “100 чацарганы шүүс” бүтээгдэхүүн шалгарсан. Тус арга хэмжээнд экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг 127 дотоодын аж ахуйн нэгж байгууллага оролцсон. “Намрын ногоон өдрүүд” -2013” үзэсгэлэн худалдаанд амжилттай оролцож “Зохион байгуулалттай” дүүргээр шалгарч өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдсан.	90.0
14.		Аж ахуйн нэгж, иргэдэд бага оврын хүчин чадалтай трактор, дагалдах хэрэгслийг хөнгөлөлттэй үнээр олгуулах боломжийг судлах, тоног төхөөрөмж шаардлагатай байгаа иргэдийн хүсэлтийг холбогдох газруудад уламжлах	ХҮХ	Бага оврын хүчин чадалтай трактор, дагалдах хэрэгслийг ХААН банкны лизинг, хөнгөлттэй үнээр ҮХААЯ-ны газар тариаланг дэмжих сангаас олгож байгааг судлан 2.0 сая төгрөгийн урьдчилгаа төлж 3 жилийн хугацаатай хүүгүй авах тухай(бага оврын ногоон трактор 5,0 сая) мэдээллийг иргэн, аж ахуй нэгж байгууллагуудад хүргүүлэн ажилласан. Үүний дагуу бага оврын трактор болон бусад техник хэрэгслийг хөнгөлттэй үнээр авах тухай 10 иргэний хүсэлтийг Үйлдвэр хөдөө аж ахуй яам, ХААН банкинд уламжлан ажилласан.	100.0
15.	1.1.6	Мал эмнэлэг, хорио цээрийн хяналтыг сайжруулж, Эмээлт дэх “Малын бирж”-ийн үйл ажиллагааг тогтмолжуулах	ХҮХ, МХХ	Дүүргийн Засаг даргын 2013 оны 234 дүгээр захирамжаар амьд мал, малын гаралтай түүхий эдийг худалдаалах үйл ажиллагааг 32-р хороо Эмээлт зах орчимд төвлөрүүлэн, “Хүн, малын гоц халдварт өвчин, Тарваган тахал өвчний халдвараас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, арга хэмжээг эрчимжүүлэх зорилгоор дүүргийн Засаг даргын 2013 оны 312 дугаар захирамжаар хяналтын постыг 24 цагаар ажиллуулан холбогдох байгууллагуудтай хамтран хяналт шалгалтыг гүйцэтгэсэн.	70.0
16.		Дүүргийн мал эмнэлэг үржлийн нэгжүүдийн үйлчилгээний хамрах хүрээнд /газар нутгийн/ дахин хуваарилалт хийх	ХҮХ	“Мал эмнэлэг үржлийн нэгжүүдийн газар нутгийг шинэчлэн тогтоох тухай” дүүргийн Засаг даргын 2013 оны 121 дүгээр захирамжаар “Бамбуу” ХХК-д 21-р хороо Жаргалант тосгоны төв орчим, Мухарын амнаас Соёондоогийн ам, Дүүрэн, Цагаан тэмээт, Оорцог, Ар гүнт, Нүхт, Рашаант, “Буян-хөхий” ХХК-д 22,	100.0

				32-р хорооны Эмээлт, Давааны зөрлөг, Долоон худаг, 361-р гарам, “Рез” ХХК-д 21-р хорооны Нарийн, Шар хадны ам, Согоот, Сүүж уул, 60-ын хоолой орчмын газар нутгийг тус тус харъяалуулан ачааллыг тэнцвэржүүлэв.	
17.		Малын эрүүл мэнд, удмын санг хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах	ХҮХ	Малын удмын санг хамгаалах ажлын хүрээнд дүүргийн Мал эмнэлгийн 3 үржлийн нэгж байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 11,2 сая төгрөгийг 109,1 толгой мал, амьтдыг вакцинжуулах ажлын зардалд олгосон. Малын эрүүл мэнд, удмын санг хамгаалах нь” сэдэвт сургагч багш бэлтгэх 14 хоногийн сургалтанд “Буянт-хөхий” ХХК-ний ажилтанг хамруулсан. “Шилмэл мал-2013”, үзэсгэлэн худалдаа нь тус дүүргийн нутаг дэвсгэр Хүй долоо худагт амжилттай зохион байгуулагдсан. Үзэсгэлэн худалдааны үеэр сүүний чиглэлийн үхрийн хээлтүүлэгчийн ангилалд 21-р хорооны иргэн Б.Төмөрбаатарын голштейн үүлдрийн 4 настай бух, хээлтэгчийн ангилалд мөн дээрх иргэний 6 настай үнээ тус тус тэргүүн байр эзэлсэн.	100.0
18.		Малчдын зөвлөгөөн зохион байгуулах	ХҮХ	Нийслэл, дүүргээс малчдын дунд авч хэрэгжүүлж байгаа бодлого шийдвэрийг танилцуулах, хэрэгжилтийг хангах, малын хулгайн гэмт хэрэг зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дүүргийн Засаг даргын 2013 оны 90 дүгээр захирамжаар “Малчдын зөвлөгөөн”-ийг Жаргалант тосгонд 2013 оны 3 дугаар сарын 14-ны өдөр 250 гаруй иргэн, фермерийн үйл ажиллагаа эрхлэгчдийг хамруулан зохион байгуулсан.	100.0
19.	1.1.7	Худалдаа, нийтийн хоолны газруудад цагийн хуваарийг мөрдүүлж, хяналтын системийг боловсронгуй болгон, камержуулах ажлыг эрчимжүүлэх	ХҮХ, ЦХ I, II	“Худалдаа үйлчилгээний байгууллагуудын ажиллах цагийн хуваарийг батлах тухай” Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/548 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр Цагдаагийн 1, 2 дугаар хэлтсүүдтэй хамтран “Шөнийн нэгдсэн арга хэмжээ” хяналт шалгалтыг зохион байгуулсан. Шалгалтаар цаг хэтрүүлэн ажилласан 6 аж ахуйн нэгж байгууллагуудад хууль хяналтын байгууллагын эрх бүхий албан тушаалтнууд холбогдох арга хэмжээг тооцож, тусгай зөвшөөрлийн эрхийг цуцлах саналыг ЗАА-ны ХХҮХ-т уламжлан шийдвэрлүүлсэн. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хяналтын системийг боловсронгуй болгож, камержуулалтыг эрчимжүүлэх ажлын хүрээнд “Жемлайф Аутсорсинг” ХХК нь худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж	90.0



				буй аж ахуйн нэгж байгууллагуудад өөрийн үндсэн үнийн тарифаас 20-30%-ийн хөнгөлөлттэй үнээр үйлчлэх тухай албан бичгээр хандан хамтран ажиллаж ирсэн. Үүний үр дүнд нийт 560 гаруй худалдааны газруудын 80 орчим хувь нь байгууллагын дотоод, 40 орчим хувь нь гадна орчныг буюу нийтдээ худалдааны 448 аж ахуйн нэгж байгууллага, нийтийн хоолны 93 аж ахуйн нэгж байгууллага камержуулсан байна.	
20.	Согтууруулах ундааны тусгай зөвшөөрөлтэй худалдаа, нийтийн хоолны газруудад холбогдох хууль, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд дүүргийн Засаг дарга аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран ажиллах гэрээг боловсруулан мөрдүүлж ажиллах	ХҮХ	Тамхины хяналтын тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, НИТХТ-ийн 63, 198 дугаар тогтоол болон бусад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд худалдааны томоохон аж ахуйн нэгж байгууллагуудын төлөөлөлийг хүлээн авч уулзан, санал бодлоо солилцож, тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, камержуулах ажлыг эрчимжүүлэх тухай үүрэг өгч, худалдааны 451, нийтийн хоолны 127 аж ахуйн нэгж байгууллагуудтай “Хамтран ажиллах гэрээ”-г байгуулж, хяналт тавин ажиллаа.	90.0	
21.	Стандартын шаардлага хангаж буй нийтийн хоолны газруудад тохирлын гэрчилгээ олгуулах	ХҮХ	Дүүргийн нутаг дэвсгэрт хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж, байгууллагаас аттестатчилалын шалгалтаар MNS 4946:2005 стандартын шаардлагыг 88-100% хангасан 5 нийтийн хоолны аж ахуйн нэгжид тохирлын гэрчилгээ олгуулхаар Стандарт хэмжил зүйн газрын бүтээгдэхүүн тогтолцоо баталгаажуулалтын албанд 2/1388 албан тоот бичгээр уламжиллаа.	90.0	
22.	Худалдаа, нийтийн хоолны газруудыг аттестатчилах хяналт шалгалтыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах	ХҮХ, МХХ	Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн баталсан удирдамжийн хүрээнд согтууруулах ундаа худалдан борлуулах тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагааг аттестатчилах хяналт шалгалтыг 2013 оны 06 дугаар сарын 12-ноос 07 дугаар сарын 19-ний өдрүүдэд зохион явууллаа. Аттестатчиллаар аж ахуйн нэгж байгууллагын орчны тохижилт, ногоон байгууламж, камержуулалт, холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж, стандарт шаардлага хангасан худалдааны 259, аж ахуйн нэгжийн согтууруулах ундаа худалдан борлуулах тусгай зөвшөөрлийн эрхийг сунгах, шинээр 3 аж ахуйн нэгжид олгох, холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилт, стандарт шаардлага хангаагүй худалдааны 49, нийтийн хоолны 41 аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн эрхийг цуцлах саналыг ЗАА-	100.0	

			ны ХХҮХ-т уламжлан шийдвэрлүүлээ.	
23.	Халуун ус, сауны газруудад мэргэжлийн байгууллагатай хамтран хяналт шалгалт зохион байгуулах, зөвлөгөө өгөх	ХҮХ, МХХ, ЦХ I, II	Стандартчилал хэмжилзүйн газрын бүтээгдэхүүн, тогтолцооны баталгаажуулалтын хэлтэстэй хамтран 5 дугаар сарын 2, 3-ны өдрүүдэд дүүргийн нутаг дэвсгэрт үйлчилгээ явуулдаг халуун ус, сауны газруудаар хяналт шалгалтыг зохион байгууллаа. Шалгалтанд 23 цэг салбар хамрагдсанаас стандартын шаардлага хангасан 3, шаардлага хангаагүй 19, үйл ажиллагаа нь жигдрээгүй 1аж ахуйн нэгжид стандартын чиглэлээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа.	100.0
24.	26-р хороонд 2 байршилд халуун усны барилгын ажил концессын гэрээгээр гүйцэтгэх жагсаалтанд орсон тул газрын асуудлыг шийдвэрлэх	ӨГХА	26-р хорооны Алтан овоо, Улаан чулуутын хогийн цэгийн баруун урд байршлыг тогтоосон.	100.0
25.	Аялал жуулчлалын байгууллагын стандартыг мөрдүүлж, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах	ХҮХ, МХХ	Нийслэлийн аялал жуулчлалын газар, Монголын зочид буудлуудын холбоотой хамтран 5 дугаар сарын 1-ны өдөр зочид буудал, зоогийн газрын үйлчилгээний ажиллагсад зориулсан “Үйлчилгээний ажилтнуудын мэргэжлийн үзүүлэх сургалт”-ыг дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй 24 зочид буудлын үйлчилгээний ажилтнуудыг хамруулан Сэнтий зочид буудалд зохион байгууллаа. Сургалтанд оролцогсдод гарын авлага материал тарааж, нийслэлийн нэгдсэн сургалтын мэдээллийг видео бичлэгээр үзүүлж танилцууллаа. “Амралтын газар, жуулчны баазын үйлчилгээний технологи, стандарт” сэдэвт сургалтыг 6-р сарын 28-ны өдөр Аялал жуулчлалын газрын сургалт мэдээллийн танхимд зохион байгуулж дүүргийн нутаг дэвсгэрийн 6 амралт жуулчны баазуудыг хамруулав. Нийслэлийн аялал жуулчлалын газар, Цагдаагийн 2-р хэлтэс, Мэргэжлийн хяналтын хэлтэстэй хамтран 11-р сарын 13-ны өдөр хэрэг зөрчил ихээр гардаг дэн буудлуудаар хяналт шалгалт хийж тулгамдаад байгаа асуудалд хууль, журмын талаар зөвлөгөө өгөн стандартыг хангуулах ажлыг зохион байгуулав. Нийт 12 газар хамрагдсанаас 3 газар стандартын шаардлага хангаж 9 газар тэнцээгүй тул мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн хугацаатай үүрэг даалгавар өгч ажиллаа.	90.0

26.	1.1.8	Байршлыг тогтоон, газрын үнийг судлах, одоо байгаа үйлчилгээний цэг, салбараа өргөтгөхөөр иргэд ААН-ийн санал санаачлагыг дэмжих	ХҮХ, ӨГХА	9-р хорооны 76-р сургуулийн баруун талд төвлөрсөн захын хэлбэрээр үйл ажиллагаа явуулах бүрэн боломжтой 3300м2 талбайтай объект зарах саналыг Түншлэл худалдааны төвөөс ирүүлснийг судалж байна. 19-р хорооны "Оюумаа" ХХК хүнсний дэлгүүрийн үйл ажиллагааг өргөтгөж худалдаа, үйлчилгээний нэр төрлийг олшруулах зорилгоор ажлын байр нэмэгдүүлэх тухай хүсэлт гаргасан тул газрын асуудлыг судалж байна.	50.0																																																																	
27.	1.1.9	Нөөцийн махны борлуулалтын ажлыг зохион байгуулах	ХҮХ	Стандартын шаардлага хангасан аж ахуйн нэгж байгууллагуудийг сонгон 32 хорооны 80 цэгээр нөөцийн мах худалдан борлуулах ажлыг зохион байгуулсан. "Өрх бүрт нэг гулууз" нөөцийн махны өргөтгөсөн худалдааг Баянхошууны тойрог, Толгойт, Цамбагарав худалдааны төвийн урд талбайд 5 удаа зохион байгуулж 54.7 тн махны борлуулалт хийгдсэн. Нөөцийн махын борлуулалтын явцад мэргэжлийн байгууллага, иргэдтэй хамтран хяналт шалгалтыг тогтмол зохион байгуулав.	100.0																																																																	
28.		Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний татан авалт, үнийн судалгааг гаргах, аж ахуйн нэгж, сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургуулиудад "Хүнсний хангамж, аюулгүй байдал" сургалтыг зохион байгуулах	ХҮХ, СХ	Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үнийн жагсаалтыг Саппоро "Миний-Зах, Хангалуун трейд, Макс групп, Хар хорин зах"-аас 9, 10, 11-р сарын үнийн судалгааг авлаа.	90.0																																																																	
				<table border="1"> <thead> <tr> <th></th> <th>НЭР ТӨРӨЛ</th> <th>9</th> <th>10</th> <th>11</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>Гурил, дээд зэрэг, "Алтан тариа" ХК, савласан /улаан/</td> <td>1003</td> <td>1536</td> <td>1002</td> </tr> <tr> <td>2</td> <td>Гурил, 1-р зэрэг, "Алтан тариа" ХК, задгай</td> <td>700</td> <td>1002</td> <td>-</td> </tr> <tr> <td>3</td> <td>Талх, "Атар", "Талх чихэр" ХК</td> <td>860</td> <td>852</td> <td>825</td> </tr> <tr> <td>4</td> <td>Цагаан будаа, кг, задгай</td> <td>1681</td> <td>1681</td> <td>2085</td> </tr> <tr> <td>5</td> <td>Хонины ястай мах, кг</td> <td>7133</td> <td>6833</td> <td>6765</td> </tr> <tr> <td>6</td> <td>Үхрийн ястай мах, кг</td> <td>8267</td> <td>8000</td> <td>8075</td> </tr> <tr> <td>7</td> <td>Адууны ястай мах, кг</td> <td>6250</td> <td>6150</td> <td>6250</td> </tr> <tr> <td>8</td> <td>Ямааны ястай мах, кг</td> <td>5900</td> <td>5900</td> <td>5900</td> </tr> <tr> <td>9</td> <td>Сүү, задгай, литр</td> <td>800</td> <td>800</td> <td>1000</td> </tr> <tr> <td>10</td> <td>Сүү, савласан, "Элекстер", 500 гр</td> <td>696</td> <td>695</td> <td>738</td> </tr> <tr> <td>11</td> <td>Төмс, Монгол, кг</td> <td>685</td> <td>685</td> <td>657</td> </tr> <tr> <td>12</td> <td>Лууван, дотоод, кг</td> <td>1800</td> <td>1583</td> <td>1200</td> </tr> </tbody> </table>		НЭР ТӨРӨЛ	9	10	11	1	Гурил, дээд зэрэг, "Алтан тариа" ХК, савласан /улаан/	1003	1536	1002	2	Гурил, 1-р зэрэг, "Алтан тариа" ХК, задгай	700	1002	-	3	Талх, "Атар", "Талх чихэр" ХК	860	852	825	4	Цагаан будаа, кг, задгай	1681	1681	2085	5	Хонины ястай мах, кг	7133	6833	6765	6	Үхрийн ястай мах, кг	8267	8000	8075	7	Адууны ястай мах, кг	6250	6150	6250	8	Ямааны ястай мах, кг	5900	5900	5900	9	Сүү, задгай, литр	800	800	1000	10	Сүү, савласан, "Элекстер", 500 гр	696	695	738	11	Төмс, Монгол, кг	685	685	657	12	Лууван, дотоод, кг	1800	1583	1200	
	НЭР ТӨРӨЛ	9	10	11																																																																		
1	Гурил, дээд зэрэг, "Алтан тариа" ХК, савласан /улаан/	1003	1536	1002																																																																		
2	Гурил, 1-р зэрэг, "Алтан тариа" ХК, задгай	700	1002	-																																																																		
3	Талх, "Атар", "Талх чихэр" ХК	860	852	825																																																																		
4	Цагаан будаа, кг, задгай	1681	1681	2085																																																																		
5	Хонины ястай мах, кг	7133	6833	6765																																																																		
6	Үхрийн ястай мах, кг	8267	8000	8075																																																																		
7	Адууны ястай мах, кг	6250	6150	6250																																																																		
8	Ямааны ястай мах, кг	5900	5900	5900																																																																		
9	Сүү, задгай, литр	800	800	1000																																																																		
10	Сүү, савласан, "Элекстер", 500 гр	696	695	738																																																																		
11	Төмс, Монгол, кг	685	685	657																																																																		
12	Лууван, дотоод, кг	1800	1583	1200																																																																		

				<table border="1"> <tr> <td>13</td> <td>Манжин, дотоод, кг</td> <td>1616</td> <td>1530</td> <td>1413</td> </tr> <tr> <td>14</td> <td>Байцаа, Хятад, кг</td> <td>1228</td> <td>1100</td> <td>1071</td> </tr> <tr> <td>15</td> <td>Сонгино, Хятад, кг</td> <td>1128</td> <td>1085</td> <td>1071</td> </tr> </table> <p>2013 оны 09-р сарын 10-ны өдөр Эрүүл мэндийн нэгдлийн Хоол, шим тэжээлийн боловсрол олгох төвтэй хамтран дүүргийн нутаг дэвсгэрийн 15 зоогийн газрын 30 гаруй тогооч нарыг хамруулан “Эрүүл аюулгүй хүнс, зохистой хооллолт, хүнсний аюулгүй байдал”-ын тухай сургалтыг зохион байгууллаа. 3-р сарын 22-ны өдөр 156 дугаар цэцэрлэгийн тогооч, багш болон эцэг эхчүүдийг хамруулан “Эрүүл хүнс зөв зохистой хооллолт, тэжээлийн дутлаас урьдчилан сэргийлэх тухай” сэдэвт сургалт, хоолны өдөрлөгийг зохион байгуулсан. “Урамтай урамшуулал, хэмнэлттэй хямдрал” худалдаанд дүүргийн нутаг дэвсгэрийн мах, сүү, гурилын зэрэг 10 гаруй томоохон аж ахуйн нэгж байгууллагууд оролцож, бүтээгдэхүүнээ агуулахын болон бөөний үнээр худалдаалж 1000 гаруй ард иргэдэд үйлчилсэн.</p>	13	Манжин, дотоод, кг	1616	1530	1413	14	Байцаа, Хятад, кг	1228	1100	1071	15	Сонгино, Хятад, кг	1128	1085	1071	
13	Манжин, дотоод, кг	1616	1530	1413																
14	Байцаа, Хятад, кг	1228	1100	1071																
15	Сонгино, Хятад, кг	1128	1085	1071																
29.	1.1.10	Архи, согтууруулах ундааны хууль бус сурталчилгааг таслан зогсооход мэргэжлийн байгууллагуудтай хамтран хяналт шалгалтыг зохион байгуулах, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах	ХҮХ, МХХ, ЦХ I, II	<p>Холбогдох хууль, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр хууль хяналтын болон холбогдох байгууллагуудтай хамтран хяналт шалгалтыг худалдааны 860 гаруй, нийтийн хоолны 48 аж ахуйн нэгж байгууллагыг хамруулан зохион байгуулж, заавар зөвлөгөө өгч ажиллав. Архи тамхины борлуулалтыг нэмэгдүүлэх үүднээс тухайн бүтээгдэхүүнийг сурталчилсан зурагт хуудсаар хямдрал зарласан, насанд хүрээгүй хүүхдэд согтууруулах ундаа худалдсан, цаг хэтрүүлэн ажилласан, ЕБС-иас 500м-ийн тойрогт байршилтай газрууд тамхи худалдаалсан, зохих зөвшөөрөлгүй согтууруулах ундаа худалдан борлуулсан зэрэг зөрчил дутагдалд хууль, мэргэжлийн хяналтын байгууллагууд холбогдох арга хэмжээнүүдийг тооцож, хүнсний дэлгүүрүүдэд байршуулсан тамхины хямдрал, архины сурталчилгааны зурагт хуудсуудыг буулгууллаа. Архидалт мансуурлын эсрэг ассоциаци ТББ-тай хамтран 32 хорооны Засаг дарга, нийгмийн ажилтнуудад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, архи тамхины сурталчилгааг таслан зогсоох чиглэлээр сургалт зохион байгууллаа. Сургалтын үеэр архи мансууруулах бодисын зохисгүй хэрэглээний талаарх видео бичлэг үзүүлж, хуурцаг, гарын авлага материал тараалаа.</p>	90.0															

30.		Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн хэрэгжилтийг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах	ХҮХ, ЗХХ, МХХ,ЦХ I, II	Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан дүүргийн Засаг даргын 2013 оны 163, 184 дугаар захирамжаар ЕБС-аас 500м-ийн радиуст байрлах худалдааны 432, нийтийн хоолны 65 аж ахуйн нэгжийн тамхи худалдаалах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгон хяналт тавьж ажилласан. Цагдаагийн хэлтсээс албан мэдэгдлийг аж ахуйн нэгж байгууллагуудад хүргэн, хамтарсан хяналт шалгалтыг худалдааны 830 /давхардсан тоогоор/ гаруй аж ахуйн нэгж байгууллагуудыг хамруулан зохион байгууллаа. Хяналт шалгалтын хүрээнд зөрчил гаргасан 8 аж ахуйн нэгжид Тамхины хяналтын тухай хуулийн холбогдох заалтын дагуу хууль бусаар худалдаалж байсан 25 нэр төрлийн 572ш тамхийг улсын орлогод хураан авч, 4.7 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээг тооцож ажилласан.	100.0
31.		Залуучуудад зориулсан “Архигүй” цэнгээний жишиг нийтийн хоолны газрыг дүүрэгт бий болгох	ХҮХ	Нийслэлийн Засаг даргын 2013 оны 06 сарын 12-ны өдрийн А/584 дугаар захирамжаар батлагдсан “Архигүй цэнгээний газар”-ын ажиллах журмын 3.1-д Архигүй цэнгээний газрыг Хотын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны эзэмшил газар болох Туул болон Дунд голын эргийн орчимд байгуулна гэж заасан тул манай дүүрэгт байгуулах боломжгүй байна. Дүүргийн нутаг дэвсгэрт хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Алдар тэс ХХК-ны залуусын чөлөөт цагийг архи, тамхигүй орчинд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх “Архигүй цэнгээний газар” нээх хүсэлтийг дүүргийн ЗДТГ-ын 3/1868 тоот албан бичгээр ЗАА-нд уламжлан хүргүүлэв.	70.0
32.		Худалдаа, үйлчилгээнд даавуун тор, цаасан уутны хэрэглээг нэмэгдүүлэх	ХҮХ	Худалдаа үйлчилгээнд стандартын сав баглаа боодол, даавуун тор, цаасан уутны хэрэглээг нэмэгдүүлэх ажлын хүрээнд МТ маркет ХХКомпаний эко торыг худалдаанд нэвтрүүлэх санал, санаачлага гаргасныг дэмжин, гялгар уутны хор уршгийн талаарх сургалтыг МТ маркет ХХКомпаний байранд худалдааны 80 гаруй аж ахуйн нэгж байгууллагуудыг хамруулан зохион байгуулсан. Тус байгууллага дүүргийн нутаг дэвсгэрт худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудад өөрийн компанийн лого бүхий даавуун торыг 1 багц буюу 100ш-ийг 15000 төгрөгөөр худалдаж, одоогийн байдлаар 410 гаруй аж ахуйн нэгж	90.0

				хамрагдаж 4100 багцыг худалдаанд нийлүүлэн хэрэглээг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллаа.	
33.	1.1.11	Иргэн бүрт газар өмчлүүлэх ажлыг үргэлжлүүлэх	ӨГХА	“Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай” хуулийн дагуу нийслэлийн Засаг даргын 12 захирамжаар 3999 иргэнд, хамтран өмчлөгч хасуулсан болон кадастрын зураг өөрчлөгдсөн 1012 иргэнд, илүү талбайгаа үнээр худалдаж авсан 16 иргэнд тус тус нэг удаа үнэгүйгээр газар өмчлүүлсэн бөгөөд өссөн дүнгээр нийт 26703 өрхөд 1602.18 га газрыг тус тус өмчлүүлсэн байна. Үүнээс 22324 өрхөд үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээг олгон газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулах нөхцлийг бүрдүүлсэн байна.	100.0
34.		Хотын ногоон бүсэд зуслангийн зориулалтаар эзэмшиж буй газрыг иргэдэд өмчлүүлэх ажлыг эхлүүлэх	ӨГХА	Зуслангийн зориулалтаар 24-р хороо Баруунсалаа Салхитын аманд 2,2 га эзэмшиж байгаа газрыг өмчлүүлэхээр төлөвлөгөөнд тусгасан ба өмчлөх боломжтой айлуудын судалгааг Нийслэлд хүргүүлсэн.2013 онднийслэлийн хэмжээнд Сүхбаатар, Чингэлтэй дүүрэгт зуслангийн зориулалтаар эзэмших эрх бүхий айлуудын өмчлөлийн өргөдлийг хүлээж авч байгаа болно.	-
35.	1.1.12	Монголын үсчин гоо засалчдын холбоотой хамтран мэргэшүүлэх сургалт зохион байгуулах, дүүргийн аварга үсчин, гоо засалч шалгаруулах тэмцээн зохион байгуулах	ХҮХ	Монголын үсчин гоо засалчдын холбооны харъяа “Оюунлаг хатад” сургалтын төв дүүргийн Хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй ажилгүй 80 иргэнийг үсчин гоо засалч, гар урлалын чиглэлээр мэргэжлийн сургалтанд хамруулан ажлын байраар хангасан. Мөн Цэнгэл сор ХХК-ны “Зулаа” сургалтын төв 30 иргэнийг үсчин, гоо засалчийн мэргэжлийн сургалтанд хамруулан ажлын байранд зуучилсан. Дүүргийн Засаг даргын 186 дугаар захирамжийн дагуу Монголын үсчин гоо засалчдын холбоотой хамтран дүүргийн 2013 оны “Аварга үсчин гоо засалч” шалгаруулах тэмцээнийг 5 дугаар сарын 18-ны өдөр 30 гаруй үсчин гоо засалчдыг хамруулан зохион байгуулснаас Энжел салоны Юнгэрдулам аваргаар тодорч, Аваргын цом, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдлаа.	100
<b>1.2. Төсөв санхүү, хөрөнгө оруулалтын талаар</b>					
36.	1.2.1	Улс, нийслэл, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх	СТСХ, ТХ	2013 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр : - Улсын төвлөрсөн төсөвт 25117,5 сая төгрөг төвлөрүүлэхээс 25877,3 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 103.0 хувиар, - Нийслэлийн төсвийн орлогод 15893,1 сая төгрөг төвлөрүүлэхээс 16766,8 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 105.0 хувиар	100.0

				- Орон нутгийн төсвийн орлогод 5339,8 сая төгрөг төвлөрүүлэхээс 6644,2 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 124.0 хувиар тус тус биелүүлэхээр байна.	
37.	Улсын төсвийн болон орон нутгийн байгууллагуудын төсвийн төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулан оновчтой хуваарилах замаар зардлын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулан төсвөөс төлөх өргүй ажиллах чиглэл баримтлах	СТСХ, ТХ	Дүүргийн 2013 оны орон нутгийн болон тусгай шилжүүлгээр санхүүжигдэх төсөвт байгууллагуудын төсвийн хуваарийг боловсруулж дүүргийн Засаг даргаар батлуулж төсөвт байгууллагуудад хүргүүлэв. Орон нутгийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийг батлагдсан төсвийн хүрээнд жигд ханган биелүүлэхэд чиглэсэн ажлыг хийж, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллаж байна. Орон нутгийн төсвийн тодотголыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 5 дугаар хуралдаанаар 2013 оны 8 дугаар сарын 21-ний өдөр А/132 дугаар тогтоолоор батлууллаа. Уг тогтоолоор 1.107,8 сая төгрөгөөр зардлыг тодотгов. Улсын төсвийн байгууллагууд төсвөөс төлөгдөх 607,383,6 мянган төгрөгийн өртэй байна. Орон нутгийн байгууллагуудын хувьд төсвөөс төлөгдөх өргүй ажиллаж байна. Орон нутгийн төсвийн байгууллагуудад 27.304.567,9 мянган төгрөгийн зарлага санхүүжилт гаргах төлөвлөгөөтэйгээс ХБГ-ээр 27,304,567,9 мянган төгрөгийн зардал, Улсын төсвөөс тусгай шилжих эрхээр боловсролын салбарт 37.033.885,5 мянган төгрөгийн зардал гарах төлөвлөгөөтэйгээс ХБГ-ээр 37.033.885,5 мянган төгрөгийн зардал, Өрхийн эмнэлгүүдийн санхүүжилтэнд 2.728.182,4 мянган төгрөгийн зардал гарах төлөвлөгөөтэйгээс ХБГ-ээр 2.728.182,4 мянган төгрөгийн зардал гарсан байна. Боловсролын салбарын 2013 оны төсвийн төслөөр нийт 52,823,846,6 мянган төгрөг төсөвлөсөнөөс 37,033,885,5 мянган төгрөг төсөв батлагдсан нь өр үүсэх үндсэн шалтгаан болж байна. Цаашид улсын төсвийн байгууллагуудын өрийг бууруулах тал дээр онцгой анхааран ажиллаж, цалин, нийгмийн даатгалын шимтгэл, урсгал засвараас бусад зардлын санхүүжилтийг зогсоосон. Өрийн мэдээг 10 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээний гүйцэтгэлээр гаргасан бөгөөд төсвийн тодотголоор санхүүжилт нэмэгдээгүй тохиолдолд 2013 оны жилийн эцэст ХБГ-ээр 400.000,0 мянган төгрөгийн өглөгтэй гарахаар байна. Энэ нь цалин-120.000.0 мян.төг, НДШ-20.000,0, хоол-180.000,0 мян.төг байна. Төсвийн байгууллагуудын ажиллагсдад тухайн байгууллагын төсөв, хөрөнгийн талаар	90.0	

				мэдээлэл өгөх нээлттэй самбар ажиллуулах, төсвийн зарцуулалтанд тавих хяналтыг бий болгох, хөрөнгийг цаг хугацаа алдалгүй бүртгэлд хамруулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.	
38.	1.2.2	Дүүргийн дэд хөтөлбөр боловсруулж Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор батлуулан хэрэгжүүлэх	СТСХ, ТХ, СХ, ЭЗТХ	Орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх замаар өөрийгөө тэтгэх эдийн засагтай болох хөтөлбөр боловсруулах бэлтгэл ажлын хүрээнд нийслэлийн 8 дүүргийн 2008-2012 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийн динамик судалгааг өөрийн дүүрэгтэй харьцуулан гаргасан. Орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор рекламны самбар байрлуулсны, дүүргийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа элс хайрга, шар шаварны карьерүүдийн лицензний сунгалт буюу түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөрийн орлогыг тус тус төвлөрүүлэх, Монгол улсын Захиргааны хариуцлагын тухай хуулийн дагуу торгууль ногдуулах эрх бүхий албан тушаалтнуудад төлөвлөгөө хувиарлан өгөх зэрэг арга хэмжээ авч ажиллаж байна.	50.0
39.	1.2.3	Татварын хяналт шалгалтаар илэрсэн зөрчил төлбөрт тогтоосон актыг барагдуулах, шаардлагатай тохиолдолд энэ талаар олон нийтэд ил тод мэдээлэх ажлыг зохион байгуулах	ТХ	Урьд оны хяналт шалгалтын өр 1943654,7 мянган төгрөгийн өрнөөс 858361,9 мянган төгрөгийн өр барагдуулж 44,2 хувийн биелэлттэй байна Тайлант хугацаанд 731 татвар төлөгчидөд хяналт шалгалтаар 4040881,4 мянган төгрөгийн акт тавигдсанаас 2224340,2 мянган төгрөгийн өр барагдуулж 55,0 хувийн биелэлттэй байна. 6 улирал дараалан Х тайлан өгсөн болон санхүүгийн тайлангаа огт гаргаж тушаагаагүй аж ахуйн нэгж байгууллагуудын улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүй болгуулахаар Нийслэлийн Иргэний бүртгэлийн албанд хандан дээрх газруудын нэрсийг сонинд зарлуулах арга хэмжээ авч ажиллаж байна.	70.0
40.		Татварын хууль тогтоомжийг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд сурталчлах ажлыг зохион байгуулж, татварт хамрагдагсдын тоог нэмэгдүүлэх арга хэмжээ авах	ТХ	Татварын хууль тогтоомжийг сурталчлах, татвар төлөгчдийн өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд 2013 оны 3-р улирлын байдлаар давхардсан тоогоор нийт 1000 гаруй аж ахуйн нэгж, 4217 иргэнд сургалт хийж, зөвөлгөө өгсөн байна. 2012 оны байдлаар тус дүүрэгтэй 9700 аж ахуйн нэгж байгууллага, иргэн 85565 харилцдаг байсан бол 2013 оны 03-р улирлын байдлаар 10050 аж ахуйн нэгж байгууллага, иргэн 87721 болж татварын бааз суурь нэмэгдэж байна. Дүүргийн Засаг даргын 2013 оны 382	100.0



				дугаар захирамжийн дагуу тус дүүргийн нутаг дэвсгэр дээр Үл хөдлөх эд хөрөнгийн тооллого, татвар төлөгч иргэнийг бүртгэлжүүлэх ажлыг 2013 оны 9 дүгээр сарын 24-нөөс 2013 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн хооронд ажлын 30 хоногийн хугацаатай зохион байгууллаа. Бүртгэлд хамрагдсан 15886 объект, үл хөдлөх эд хөрөнгө, 3616 газар, 3140 ажлын байр хамрагдаад байна. Тооллогын явцад шинээр нэмж илрүүлсэн ажлын байр 141, объект үл хөдлөх хөрөнгө 66 бүртгэгдээд байна. Тооллогын явцад үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар 308068.8 мян.төг, ОТБТБА/орлогыг тодорхойлох боломжгүй иргэдийн орлого /патент/ ҮХЭИОАТ /үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны/ 13017.0 мян төг, жишиг ААЭО-ийн/аж ахуй эрхэлсний/ албан татвараар 61823.5 мян төгрөг, газрын ҮХХАТ 334.2 мян төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.	
41.	1.2.4	Байгууллага, аж ахуйн нэгжийн татварын болон санхүүгийн тайлан гаргах, мэдээлэх ажлыг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх	СТСХ, ТХ	Дүүргийн төсөвтэй харьцдаг аж ахуйн нэгж байгууллагуудын 2012 оны жилийн эцэс, 2013 оны 1,2,3 дугаар улирлын санхүүгийн тайланг шалгаж хүлээн авах ажлыг зохион байгуулсан байна. Тайлан тушаалт 74,2-88,0 хувьтай байна. Цаашид аж ахуйн нэгж байгууллагуудын санхүүгийн тайлан тушаалтыг тоон гарын үсэгт шилжүүлэх ажлыг эхлүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. 2013 оны 3 дугаар улирлын байдлаар 9306 аж ахуйн нэгж байгууллага тайлан тушаахаас 7492 байгууллага тушааж, тайлан тушаалт 80,5 хувьтай байна. 2013 оны 3-р улиралд дүүргийн төсөвт нийт 23600,0 мянган төгрөгийн торгуулийн орлого оруулсан. 2013 оны 10 дугаар сарын 01-25-ныхооронд 3-р улирлын тайланг "Цахим татварын мэдээллийн систем"-ээр онцгой албан татвар, НӨАТ, ААНОАТ, цалин хөлс- ТТ-11, хувь хүнд олгосон орлогоос суутган-ТТ-12 төрлийн тайланг хүлээн авлаа.	90.0
42.		Тендерийн зар, баримт бичиг худалдан авах, өгөх, тендерийн үйл ажиллагааны үр дүнг цахим хэлбэрээр харах боломж бүрдүүлнэ.	СТСХ, ХААА	Дүүргийн хөрөнгө оруулалтын 9, орон нутгийн хөгжлийн сангийн 116, нийслэлийн Засаг даргаас эрх шилжин ирсэн 20 нийт145 ажлаас 123 тендерийн зар, шалгаруулалтын явц, дүнг <a href="http://www.e-procurement.mn">www.e-procurement.mn</a> , <a href="http://www.shd.mn">www.shd.mn</a> сайтад тус тус байрлуулсан байна.	90.0
43.		Худалдан авах ажиллагааны албыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр	СТСХ, ААТ	Дүүргийн 2013 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай ИТХ-ын 5/1 дүгээр тогтоолооршаардлагатай тоног төхөөрөмж,	100.0

		хангахад дэмжлэг үзүүлэх		тавилга худалдан авахад 11.2 сая төгрөг баталж дэмжлэг үзүүлсэн.	
44.	1.2.5	Иргэдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулж 2013 онд дүүргийн нутаг дэвсгэрт хийгдэх бүтээн байгуулалт, тохижилт, хөрөнгө оруулалтын ажлын задаргааны төсөл боловсруулан холбогдох газарт уламжлах	ЭЗТХ	<p>Дүүргийн Засаг даргын 2013 оны 83 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг Сангийн сайдын 2012 оны 244 тушаалаар батлагдсан <b>“Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын дагуу</b> дүүргийн иргэдээс авсан саналыг үндэслэсэн, Хороодын Иргэдийн Нийтийн Хурлаар батлагдсан хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажлын урьдчилсан жагсаалтыг дүүргийн дунд хугацааны хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлэн дүүргийн ИТХ-д хүргүүлсэн. 32 хорооны иргэдийн дунд зохион байгуулсан санал асуулгад нийт 22702 иргэн оролцож 99 чиглэлийн давхардсан тоогоор 71317 санал ирүүлснийг авч үзэхэд:</p> <ul style="list-style-type: none"> <li>▪ Гэрэлтүүлэгтэй болох</li> <li>▪ Гудамж талбайг тохижуулах</li> <li>▪ Ногоон байгууламж байгуулах</li> <li>▪ Усан сан, худаг барих</li> <li>▪ Автобусны буудлыг шинээр барих, тохижуулах</li> <li>▪ Хүүхэд, залуучуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх газартай болох</li> <li>▪ Гудамж, талбайг хяналтын камертай болгох</li> <li>▪ Явган хүний зам, гүүр барих</li> <li>▪ Иргэний танхимыг тохижуулах</li> <li>▪ Хорооны цогцолбор байртай болох зэрэг саналууд голлох байр суурийг эзэлсэн байлаа.</li> </ul> <p>Нийтийн эзэмшлийн зам, талбайд хийгдэх бүтээн байгуулалт, тохижилтын чиглэлээр томоохон ажлуудыг санхүүжүүлэхээр батлагдсан 861.8 сая төгрөгийн хөрөнгөөр дүүргийн Засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийн 2013 оны зорилтод тусгагдсан ажлууд болон цаг үеийн нэн шаардлагатай төсөл хөтөлбөр, арга хэмжээнүүдийг санхүүжүүлэхээр төлөвлөж 2013 онд Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр хийгдэх хөрөнгө оруулалтын ажлын жагсаалтыг хороодын ИНХ-ын тогтоолыг үндэслэн гаргаж</p>	100.0

				дүүргийн ИТХ-д хүргүүлэн Тэргүүлэгчдээр хэлэлцүүлж ИТХ-ын Тэргүүлэгчдийн А/89 дугаар тогтоолоор ажлын жагсаалтыг батлуулсан. Мөн дүүргийн Засаг даргын 228 дугаар захирамжаар 2013 онд хийгдэх ажлыг жагсаалтыг батлан хөрөнгө оруулалт, тохижилтын худалдан авах ажиллагааг зохион байгуулахыг холбогдох албан тушаалтнуудад үүрэг болгов.																
45.		Орон нутгийг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын ажлын явцад хяналт тавьж, гүйцэтгэл үр дүнг иргэд олон нийтэд мэдээлэх	ЭЗТХ	Зөвлөх үйлчилгээний тендер зарлан төсөл арга хэмжээний зураг, төсвийг боловсруулснаар Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх 4,2 тэрбум төгрөгийн 116 ажлын жагсаалтыг Засаг даргын 324 дүгээр захирамжаар шинэчлэн гаргаж 6 үнэлгээний хороо байгуулан ажиллав. 10-р сарын 30-ны байдлаар 17 ажил бүрэн дуусч 531,9 сая төгрөг олгон, 75 ажил гүйцэтгэчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулан ажлыг эхлүүлж, 24 ажлын зураг батлуулах шатандаа байна. Тохижилт, хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах үнэлгээний хороодын бүрэлдэхүүнд иргэдийн төлөөллийг оролцуулан хяналт тавих нөхцөл, боломжийг бүрдүүлж байгаа ба тендерийн урилга, ажлын явцыг дүүргийн веб сайтад байрлуулан иргэдэд мэдээлж байна. Сангийн яам “Тэнгэр-ТББ”-тай хамтран 2013 оны Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр хийгдэх хөрөнгө оруулалтын ажлын явцад хөндлөнгийн үнэлгээ хийж, иргэд, тухайн ажлыг зохион байгуулж буй ажлын хэсгийн гишүүдээс судалгаа авсан.	90.0															
46.	1.2.6	Дүүргийн өмчийн эд хөрөнгийн үзлэг, тооллогыг явуулж, үр дүнг холбогдох байгууллагуудад тавьж, өмчийн менежмент, эрх зүйн орчин бүрдүүлэхэд анхаарах	СТСХ, ӨГХА	Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/431 дүгээр захирамжийг үндэслэн эд хөрөнгийн үзлэг, тооллогыг удирдан зохион байгуулах тооллогын комиссыг дүүргийн Засаг даргын 2013 оны 181 дүгээр захирамжаар томилсон. Нийслэл, дүүргийн өмчийн эд хөрөнгийн үзлэг тооллогыг хороод, СӨХ зэрэг газруудад зохион байгуулж 2013 оны 06 дугаар сарын 01-ний дотор дуусган нэгтгэлийг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт хүргүүлэв. Тооллогоор дүүргийн хэмжээнд:	100.0															
				<table border="1"> <thead> <tr> <th>Д/д</th> <th>Хөрөнгийн дансны ангилал</th> <th>Нийт дүн / мян.төг/</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>Нийтийн зориулалттай авто зам</td> <td>10563850,5</td> </tr> <tr> <td>2</td> <td>Нийтийн зориулалттай гүүр</td> <td>890206,1</td> </tr> <tr> <td>3</td> <td>Нийтийн зориулалттай явган зам</td> <td>480492,7</td> </tr> <tr> <td>4</td> <td>Үерийн хамгаалалтын байгууламж,</td> <td>48384,0</td> </tr> </tbody> </table>	Д/д	Хөрөнгийн дансны ангилал	Нийт дүн / мян.төг/	1	Нийтийн зориулалттай авто зам	10563850,5	2	Нийтийн зориулалттай гүүр	890206,1	3	Нийтийн зориулалттай явган зам	480492,7	4	Үерийн хамгаалалтын байгууламж,	48384,0	
Д/д	Хөрөнгийн дансны ангилал	Нийт дүн / мян.төг/																		
1	Нийтийн зориулалттай авто зам	10563850,5																		
2	Нийтийн зориулалттай гүүр	890206,1																		
3	Нийтийн зориулалттай явган зам	480492,7																		
4	Үерийн хамгаалалтын байгууламж,	48384,0																		

				далан суваг		
				5	Нийтийн зориулалттай гэрэлтүүлэг	2428102,4
				6	Нийтийн зориулалттай ногоон байгууламж	1682115,0
				7	Нийтийн зориулалттай хөшөө дурсгал	321990,0
				8	Нийтийн зориулалттай усан оргилуур	1200,0
				9	Нийтийн зориулалттай спорт, хүүхдийн тоглоомын талбай	2931101,8
				10	Нийтийн зориулалттай автобус болон таксины зогсоол	845027,6
				11	Нийтийн зориулалттай худаг услалтын систем	522735,0
				12	Бусад нийтийн зориулалттай эд хөрөнгө	245981,9
				13	ДҮН	20961187,9
				Нийт 20961187,9 мянган төгрөгийн хөрөнгүүд нэгтгэгдсэн байна. Тооллогын үр дүнд бүртгэлгүй хөрөнгийг бүртгэлжүүлэх, актлах шаардлагатай 171 нэр төрлийн 399,6 сая төгрөгийн хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэхээр холбогдох баримт материалыг НӨХГА-нд хүргүүлээд байна.		
<b>Хоёр. Ажлын байрыг нэмэгдүүлэн, нийгмийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлнэ.</b>						
<b>2.1 Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, ядуурлыг бууруулах талаар</b>						
47.	2.1.1	Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, хороо бүрт цахим бирж ажиллуулах	НХХ, ХХ	Хороодын Засаг дарга нар, нийгмийн ажилтнуудад сургалт семинарыг зохион байгуулж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрүүдийн тухай болон Е биржийн үйл ажиллагааны талаар мэдээлэл өгсөн. Дүүргийн 32 хороодоор техник хангамж сүлжээний мэргэжилтэнтэй хамтран Е биржийн үйл ажиллагаа, киоск машины ажиллагааг шалган хороодын ажилтнуудад заавар зөвлөгөө өгч ажилласан. Хорооны ажилтнуудтай киоск машин ажиллуулах, хариуцан ажиллах талаар гэрээг шинэчлэн байгуулж, одоо 27 хороонд тус бүр 1, дүүргийн Засаг даргын Тамгын газарт-2, Татварын хэлтэст-1, Хөдөлмөрийн хэлтсийн байранд 1, нийт 31 цахим Е бирж ажиллаж байна. Интернетгүй хороодод Е биржийг ажилуулах талаар, мэдээллийг тогтмол		90.0

				шинэчилэх талаар заавар зөвлөгөө өгч, шинэчлэлтийг авах зурган гарын авлагыг боловсруулан бүх хороодод тараасан.	
96.	2.3.4	Сургууль, цэцэрлэгүүдийн гал тогооны тоног төхөөрөмжийг шинэчлэх, сургууль, цэцэрлэгийн хоолны газрын тогооч нарыг чадваржуулах	НХХ, БХ, ХҮХ	Сургуулиудын гал тогооны тоног төхөөрөмжийг шинэчлэх ажлын хүрээнд сургуулийн цайны газруудын түрээслэгч аж ахуйн нэгж байгууллагууд өөрсдийн хөрөнгөөр тоног төхөөрөмжөө сайжруулан ажиллаж, цэцэрлэгүүдэд гал тогооны шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалтыг нэгтгэн Нийслэлийн Боловсролын газарт хүргээд байна. Сургууль, цэцэрлэг бүр бага насны хүүхдэд зөв зохистой хооллолтын боловсрол олгох зорилгоор эцэг эхчүүдэд сургалт, нээлттэй хаалганы өдөрлөг үзэсгэлэнг тогтмол зохион байгуулж хэвшсэн. Нийслэлийн Боловсролын газартай хамтран 4 дүгээр сард сургууль, цэцэрлэгийн цайны газрын тогооч нар, “Үдийн цай” нийлүүлэгч аж ахуйн нэгжүүдэд сургалт зохион байгуулсан. Хоол хүнсний эрүүл ахуй, тогооч нарын ур чадвар, чадавхийг дээшлүүлэх зорилгоор цэцэрлэгүүдийн тогооч нарыг хамруулсан сургалт хийж, нийслэлийн хэмжээний үзүүлэх ажлыг 106-р цэцэрлэгийн мастер тогооч Н.Дуламсүрэнгийн туршлага дээр тулгуурлан зохион байгуулсан.					90.0
97.		Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилтэнд мэргэжлийн байгууллага, эцэг, эхийн хяналтыг тогтмолжуулж, эрсдлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах	НХХ, БХ, МХХ	“Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилт, үйл ажиллагааг чанаржуулах ажлын хүрээнд дүүргийн төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн цайны газар, хүнсний аюулгүй байдал, цэцэрлэгийн гал тогооны эрүүл ахуйн байдлыг сайжруулах зорилгоор Стандартчлал хэмжилзүйн газрын Бүтээгдэхүүн, тогтолцооны баталгаажуулалтын хэлтэстэй хамтран 2013 оны 4 дүгээр сард шалгалтыг зохион байгуулсан. Шалгалтанд ерөнхий боловсролын 15 сургууль, сургуулийн өмнөх боловсролын 33 цэцэрлэг хамрагдсан. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн А/140 тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэг 2013 оны 10 дугаар сарын 07-20-ны өдрүүдэд сургууль, цэцэрлэгүүдэд “Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилт, цэцэрлэгийн гал тогоо, цайны газрын эрүүл ахуйн байдал, хүнсний хангамж, эрүүл аюулгүйн байдалд хяналт, мониторинг хийн ажилласан. Үдийн цай хөтөлбөрийн хүрээнд эцэг, эхийн хяналтыг тогтмолжуулж,					90.0

				эрсдлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг сургуулийн захирлын тушаалаар батлагдсан “Орон тооны бус хяналтын зөвлөл” байгуулан ажиллаж үйл ажиллагаанд хяналт тавьж хэвшсэн.	
98.	2.3.5	Бага, дунд боловсролын стандартыг хэрэгжүүлэн 12 жилийн тогтолцоонд шилжих үйл ажиллагааг үргэлжлүүлэх	НХХ, БХ	Бага, дунд боловсролын стандартыг хэрэгжүүлэн ерөнхий боловсролын сургуулийг 12 жилийн сургалтын тогтолцоонд бүрэн шилжүүлэхтэй холбогдуулан багш нарын мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтууд Нийслэлийн Боловсролын Газраас батлагдсан хуваарийн дагуу хийгдэж байна. “Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх бага боловсролын сургалт технологи арга зүй” төслийн хүрээнд 12 дугаар сургууль дээр 2 сарын хугацаанд туршилт явуулж амжилттай хэрэгжин, БШУЯам болон төслийн багт үнэлэгдэн улсын хэмжээнд туршлага дэлгэрүүлэхээр БШУЯ-ны төсөл хэрэгжүүлэгч сургууль болсон.	90.0
99.	2.3.6	Сургуулиудын интернэт холболт, дотоод сүлжээ ашиглалтыг сайжруулах, компьютерийн тоог нэмэгдүүлэх	НХХ, БХ	Ерөнхий боловсролын 19 сургууль интернетэд холбогдсоноор нийт сургуулиудын 70 хувь нь суурин, цэцэрлэгүүдийн 68 хувь нь суурин, 32 хувь нь утасгүй интернетэд тус тус холбогдсон.	70.0
100.		Ерөнхий боловсролын сургуулиудын дэргэд эцэг эх, багш, сурагчдад зориулсан мэдээллийн төв, “book safe” байгуулах ажлыг эхлүүлэх	НХХ, БХ	Сургууль, цэцэрлэгүүд байгууллагынхаа үйл ажиллагааг сурталчлах, таниулах, багш эцэг эхчүүд, суралцагчдад нээлттэй байх зорилгоор “facebook”, “blog” нээн ажиллуулж, түүгээр дамжуулан мэдээллийг нийтэд ил тод, түргэн шуурхай ажиллуулж байна.	30.0
101.	2.3.7	Төрийн бус өмчийн сургууль цэцэрлэгүүдийн үйл ажиллагааг дэмжин, багшлах боловсон хүчнийг чанаржуулах ажлыг зохион байгуулах	НХХ, БХ	Дүүргийн хэмжээнд 2013-2014 оны хичээлийн жилд 23 төрийн бус өмчийн цэцэрлэг шинээр байгуулагдан, 38 цэцэрлэг, 8 сургууль үйл ажиллагаа явуулж байна. Нийслэл, дүүрэг болон бусад мэргэжлийн байгууллагуудаас зохион байгуулсан сургалт семинар, уралдаан тэмцээнүүдэд төрийн бус боловсролын байгууллагуудыг тогтмол оролцуулж байна. Дүүргийн Засаг даргын 2013 оны 192 дугаар захирамжийн дагуу төрийн болон төрийн бус өмчийн сургууль, цэцэрлэгүүдийн багш удирдах ажилтнуудын төлөөлөл 1000 багш нарын “Боловсролын шинэчлэлд хамтдаа” сэдэвт уулзалтыг 2013 оны 5 дугаар сарын 16-ны өдөр МҮЭСТОрдонд зохион байгуулсан. Дүүргийн Засаг даргын 117 дугаар захирамжийн дагуу “Төгсөлтийн баяр” сарын аяныг ерөнхий боловсролын сургуулиудын төгсөх ангийн	70.0

				сурагчдын дунд зохион байгуулж, бүтээлч ажлаар “Гэрэлт–Ирээдүй” дунд сургууль шалгарч Засаг даргын өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдсан.	
102.	2.3.8	Гэгээрэл хөгжлийн төвийн байр барих хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлүүлэн, ззэмшил газрыг хашаажуулан хамгаалах	НХХ, ГХТ	Гэгээрэл хөгжлийн төвийн байрыг 62-р сургуулийн хашаанд барихаар газрын асуудлыг шийдвэрлэсэн байна.	90.0
103.		Насан туршийн боловсролын төв болон өргөжиж байгаатай холбогдон санхүүжилтийг орон нутгийн төсвийн тодотголоор шийдвэрлэх	НХХ, ГХТ	Албан бус боловсролын Гэгээрэл хөгжлийн төв Насан туршийн боловсролын төв болон өргөжих асуудал шийдэгдээгүй тул санхүүжилтийг төсвийн тодотголоор шийдвэрлэх шаардлагагүй болсон.	-
104.		Сургууль завсардалтыг бууруулах ажлыг эрчимжүүлж, шинээр боловсрол нөхөн олгох сургалтын танхимыг хамран сургах тойргийг түшиглэн хичээллүүлэх боломжийг нэмэгдүүлэх	НХХ, ГХТ	Албан бус боловсролын Гэгээрэл хөгжлийн төвд 2013-2014 оны хичээлийн жилд боловсрол нөхөн олгох сургалтанд 12, 76 дугаар сургууль дээр шинээр нэг анги нээн хичээллүүлж, бага боловсролд 112, суурь боловсролд 53 хүүхэд нийт 165 хүүхэд суралцаж байна. Дүйцсэн хөтөлбөрийн боловсрол нөхөн олгох сургалтанд суралцах боломжтой иргэдийг хамруулах ажлыг хороодтой хамтран зохион байгуулж, сургуульд суугаагүй болон огт суугаагүй бичиг үсэггүй иргэдийн судалгааг шинэчлэсэн. Сургууль завсардсан болон огт суугаагүй суралцах хүсэлтэй 111, огт суугаагүй суралцах боломжгүй хүүхэд 50, сурах хэрэгцээ сонирхолтой 77 иргэнийг илрүүлэн сургалтандаа хамруулан сургаж байна.Хүн амын дунд бичиг үсэг үл мэдэх явдлыг багасгах зорилгоор цэргийн насны иргэдийн бичиг үсэггүй болон сургууль завсардалтын судалгааг 2013 оны 5, 10 дугаар сард зохион байгуулагдсан цэрэг татлагаар авч, сургууль завсардсан 61, огт суугаагүй бичиг үсэггүй 32 иргэнийг тус тус илрүүлэн, бичиг үсгийн анхан шатны 240 цагийн сургалтанд 20 иргэнийг хамруулан сургаад байна.	90.0
<b>2.4.Соёл, урлагийн чиглэлээр</b>					
105.	2.4.1	Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг хотын түүх, соёлын дурсгалт газруудтай танилцах ажлыг зохион байгуулах	НХХ	Хүүхдийн баяраар хөгжлийн бэрхшээлтэй 32 хүүхдийг Мандширын хийд чиглэлээр тойрон аялалд хамруулсан. Дүүргийн Засаг даргын 2013 оны 355 дугаар захирамжаар Түүх соёлын үл хөдлөх, хөшөө дурсгалын газруудаар ЕБС-ийн 2500 гаруй сурагчдыг хамруулан танин мэдэхүйн аялал зохион	100.0



			байгууллаа.	
106.	Соёлтой өрх, хороо шалгаруулан дүгнэх	НХХ	Нийслэлийн 374 жилийн ойг угтаж, дүүргийн Засаг даргын 354 дүгээр захирамжаар соёлтой өрх, хороог шалгаруулав. Ард иргэдийнхээ ая тухтай, соёлтой амьдрах орчныг бүрдүүлсэн Б.Энхтуяа Засаг даргатай 6 дугаар хороо тэргүүн байранд шалгарч, Л.Төмөрбаатар Засаг даргатай 24 дүгээр хороо дэд байр, Х.Эрдэнэтуяа Засаг даргатай 8 дугаар хороо гуравдугаар байр, Л.Бямбадорж Засаг даргатай 9 дүгээр хороо дөрөвдүгээр байранд тус тус шалгарсан байна. Мөн энэ үеэр 5 дугаар хорооны нийгмийн ажилтан Д.Баярбат, 12 дугаар хорооны нийгмийн ажилтан Ж.Чулуун, 16 дугаар хорооны нийгмийн ажилтан Б.Аззаяа, 27 дугаар хорооны нийгмийн ажилтан О.Ариунжаргал нарыг шилдэг нийгмийн ажилтнаар шалгаруулж, өөрийн хүч хөдөлмөр, санал санаачилгаар хүрээлэн буй орчноо тохижуулсан 7 дугаар хорооны иргэн Б.Чинболд, 6 дугаар хорооны иргэн Ц.Мягмардулам, 26-р хорооны иргэн Э.Туул, 31-р хорооны иргэн О.Баасанхүү нарыг соёлч гэр бүлээр шалгаруулан Засаг даргын өргөмжил мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа.	100.0
107.	Иргэдийн нийтийн соёлыг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх ажлыг бүх нийтийн аян болгох бүтээлч ажлыг зохион байгуулах	НХХ	Дүүргийн засаг даргын 2013 оны 29 дүгээр захирамжаар 2013 оны 02 дүгээр сарын 25-26-ны өдрүүдэд дүүргийн ЕБС, цэцэрлэгүүдийн дунд сургуулийн өмнөх нас ба цэцэрлэг, сургуулийн бага нас, дунд нас, ахлах нас гэсэн ангиллаар "Уран жиргээ – 2013 " уран уншлагын уралдааныг амжилттай зохион байгууллаа. Тус уралдаанд нийт 15 цэцэрлэгийн 43 багачууд Ерөнхий боловсролын 20 сургуулийн 100 гаруй сурагчид оролцсноос 12 хүүхэд Нийслэлийн уралдаанд оролцох эрхийн бичиг, Засаг даргын өргөмжлөл мөнгөн шагналаар шагнууллаа. Олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан ард түмний дунд авьяастуудыг илрүүлэх, тодруулах, тэдэнд дэмжлэг үзүүлэх зорилгоор зохион байгуулагдаж байгаа "Авьяаслаг гэр бүл" шалгаруулах уралдааны анхан шатны шалгаруулалтыг дүүргийн Засаг даргын 2013 оны 154 тоот захирамжаар 5 дугаар сарын 10-нд дүүргийн хэмжээнд зохион байгуулсан. Тус уралдаанд 23-р хорооны ардын авьяастан Юндэндоржийн гэр бүл тэмцээний 1 дүгээр байр, 2 дугаар байранд 22-р хорооны ардын авьяастан Алт-Оросоогийн гэр бүл, 3-р байрыг 21-р хорооны Очирхандын гэр	100.0

				<p>бүл тус тус эзэллээ. Гэр хорооллын хурлын заалыг ашиглан бичил номын сангийн тоог нэмэгдүүлэх зорилгоор Тайваны “Хүүхэд, гэр бүлийг дэмжих сан”-д 10, 5, 8, 7, 32 хороодод “Номын өргөө” байгуулах төслийг боловсруулан дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2013 оны 6/332 тоот албан бичгээр хүргүүлээд байна. Нийслэлийн Засаг даргын А/611 дүгээр захирамжийн дагуу “Дээлтэй Монгол 2013” наадамд Засаг даргын орлогчоор ахлуулан 10 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулан ажиллалаа. Энэ удаагийн наадамд хөгжлийн бэрхшээлтэй иргэдээ түлхүү дэмжин циркийн могойн болон жонгилортой үзүүлбэр, арван морьтон баатрууд зэрэг нилээд шинэлэг ажлуудыг зохион байгуулж өргөн хүрээнд амжилттай оролцлоо. Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын жүжигчин Д.Лувсаншаравын нэрэмжит “Хүүхдийн найрал дууны наадам”-ыг дүүргийн Засаг даргын 375 дугаар захирамжаар уралдааныг ЕБС-уудын дунд 2013.10.09-ны өдөр зохион байгууллаа. Тэргүүн байранд Ирээдүй цогцолбор сургууль, хоёрдугаар байранд 9-р сургууль, 3 дугаар байранд 42 дугаар сургууль, тусгай байранд 106 сургууль орлоо. Шилдэг багшаар 9 сургуулийн Саранцэцэг багш, шилдэг найруулагч багшаар 65-р сургуулийн дууны багш Бямбадорж нар шалгарлаа.</p>	
108.	2.4.2	Монголын уламжлалт урлаг, өв соёлыг сурталчлах өвлүүлэн хөгжүүлэх чиглэлээр Морин хуур Уртын дуу, Бий биелгээ, Монгол Хөөмий, Монгол тууль үндэсний хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	НХХ	<p>Улаанбаатар чуулгатай хамтран “Монгол уртын дуугаа өвлөн дэлгэрүүлэе” 3 сарын сургалтанд 14 ардын авьяастныг сургаж байна. Жаргалант тосгоны Соёлын төвд морин хуур, уртын дуу, бий биелгээ, монгол хөөмий дугуйлангуудад 62 хүүхдийг хамруулаад байна. “Монголын уламжлалт бий биелгээ” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд Соёл спорт аялал жуулчлалын яам “Хөгсүү” чуулгатай хамтран Монголын бий биелгээ өвлүүлэх холбооны багш Баяртай Монгол үндэсний бий биелгээ бүжгийг язгуур төрхөөр нь дүүргийн 15 сургуулийн 700 гаруй сурагчдад зааж сургаж байна. Мөн дүүргийн улсын өмчийн цэцэрлэгийн дуу хөгжмийн багш нарыг бий биелгээ бүжгийн сургагч багш бэлтгэх 5 удаагийн сургалтанд хамруулж гарын авлага, ном, DVD зэргийг олгоод байна. Уг сургалтанд 37 багш хамрагдсан. “Монгол тууль” хөтөлбөрийн хүрээнд дүүрэгт амьдардаг утга соёлын өв тээгч туульч 3 ардын авьяастанг бүртгэн авсан. 18-р хорооны ардын авьяастан Б.Гантөмөр 19-р</p>	100.0

			хорооны ардын авьяастан Д.Отгондорж, О.Баянбулаг нартай уулзалт зохион байгуулан хөтөлбөр боловсруулан ажиллах талаар санал солилцсон болно.	
109.	Түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсийн хадгалалт хамгаалалт, орчны тохижилтыг сайжруулах, сурталчлах ажлыг зохион байгуулах	НХХ	<p>Дүүргийн түүх соёлын үл хөдлөх дурсгалт газруудын мэдээллийн санг шинэчилсэн байдлаар гарган Нийслэлийн Соёл урлагийн газар хүргүүлэв. Нийслэлийн нутаг дэвсгэрт байрлах “Түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлс”-ийн хадгалалт, хамгаалалт, Соёлын өвийг хамгаалах тухай” хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих зорилгоор дүүргийн нутаг дэвсгэрт байрлах хөшөө дурсгалын газруудаар үзлэг шалгалт хийлээ. Шалгалтыг дүүргийн Засаг даргын 2013 оны 88 дугаар захирамжаар 250,0 мянган төгрөгийн зардал гарган Нийслэлийн Соёл урлагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Улаанбаатар хотын музей, Нийслэлийн өмчийн газартай хамтран 2013 оны 3 дугаар сарын 22-ны өдөр дүүрэгт байрлах 12 хөшөө дурсгалын газруудаар хийлээ</p> <p>Шалгалтанд: 1.СХД-ийн дүүргийн өндөрлөг  2.Чингисийн цээж баримал  3.Ц.Филатовагийн цээж баримал  4.Морьтой баатар  5.Цагаан хаалга  6.Сүхбаатарын цээж баримал  7.Янгирын хөшөө  8.МИ-8 осолд орсон ОБА-д зориулсан дурсгалын хөшөө  9.Сонгиохайрхан уулан дахь Хэлмэгдсдийн хөшөө  10.Хилчин холбоочдын дурсгалын хөшөө  11.Сүхбаатарын цээж баримал  12. Жанчив баатарын хөшөө хамрагдсан болно.</p>	100.0
110.	Соёлын биет болон бус өвийн бүртгэл мэдээллийн санг баяжуулах	НХХ	<p>Дүүргийн соёлын өвийн бүртгэл мэдээллийн санг шинэчлэн Засаг даргын 6/317 тоотгоор нийслэлийн СУ-ын газарт хүргүүлээд байна.</p> <p>Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Морин хуурч – 21</li> <li>2. Уртын дууч - 32</li> <li>3. Хөөмийч- 6</li> <li>4. Ардын болон зохиолын дуу- -30</li> </ol>	100.0

				<p>5. Монголын уламжлалт бий биелгээ-13  6. Ерөөлч магтаалч -5  7. Уран хатгамалч -12  8. Үндэсний бөхийн цол -18  9. Нугараач -1  10. Шагай харваач -1</p> <p>Дүүргийн хэмжээнд утга соёлын өв тээгч -164 иргэн бүртгэгдээд байна. Нийслэлийн соёл урлагийн газраас “Соёлын биет бус өвийг бүртгэн баримтжуулах, бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх арга зүй” сэдэвт 22 гарын авлагыг хороодын нийгмийн ажилтануудад тараасан. Дүүргийн ЕБ-ын 13 сургуульд ардын хөгжмийн 33 дугуйлан хичээллэж соёлын өвийг сурталчилж байна.</p>	
111.		Нийслэлийн хөөмийчдийн наадам зохион байгуулах	НХХ	<p>“Монгол хөөмий” дэд хөтөлбөрийн хүрээнд дүүргийн Засаг даргын 427 дугаар захирамжаар Нийслэлийн Соёл урлагийн газар, Жаргалант тосгоны соёлын ордонтой хамтран жил болгон уламжлал болон зохион байгуулагддаг “Хөөмийн уянга 2013” хөөмийчдийн гурав дахь удаагийн уралдааныг нийслэлийн хэмжээнд 2013 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр “Жаргалант” тосгоны соёлын ордонд хоёр насны ангилалаар зохион байгууллаа. Уг уралдаанд 20 гаруй авьяаслаг хөөмийчид оролцож насанд хүрэгчдийн ангилалд “Гранпри” шагналыг Соёл урлагийн их сургуулийн 1 дүгээр дамжааны оюутан Б.Чинбат, удаах байранд тус сургуулийн 1- дамжааны оюутан Ц.Хаш-эрдэнэ, Дармаа нар шалгарлаа. Өсвөр насны ангилалд тэргүүн байранд Хан-уул дүүргийн сурагч Б.Санжаажав, удаах байранд Хан-уул хамтлаг, Л.Эрдэнэжав, Тэмүүлэн нар шалгаран Засаг даргын өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнуулсан.</p>	100.0
112.	2.4.3	“Бид Сонгинохайрханчууд” урлагийн наадам зохион байгуулах	НХХ	<p>“Бид Сонгинохайрханчууд” урлагийн наадмыг төлөвлөгөөний дагуу 2013 оны 12 сард зохион байгуулахаар удирдамжийг боловсруулан батлуулж ажиллаж байна.</p>	90.0
113.	2.4.4	Соёлын төвийн ажлыг эхлүүлэх	НХХ	<p>Дүүргийн Засаг даргын нийгмийн бодлого хариуцсан орлогч даргын 2013 оны 05 сарын 24-ны 2/851 тоотойр УИХ-ын гишүүн Л.Эрдэнэчимэг, Аялал жуучлалын сайд, нийслэлийн Соёл урлагийн газрын дарга нарт дүүргийн Соёлын ордон бариулах газрын захирамж болон холбогдох бичиг баримтыг хавсарган</p>	70.0

				хүргүүлээ. Соёл спорт, аялал жуулчлалын сайдын 2013 оны 07 дугаар сарын 02-ны 9/851 тоотой дүүргийн соёлын ордны барилгын ажлын хөрөнгө оруулалтыг шийдүүлэх талаар 2014 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгах тухай албан бичиг ирсэн болно. Эдийн засгийн хөгжлийн сайдад хандан дүүргийн Соёлын ордны хөрөнгө оруулалтын төсвийг шийдвэрлүүлэх талаар 2013 оны 09 дүгээр 09-ний 2/1421 албан тоотой хүргүүлээ.	
<b>2.5. Хүүхэд, залуучуудын талаар</b>					
114.	2.5.1	Хүүхэд хөгжлийн төвийн байрны асуудлыг шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллагуудад уламжлах	НХХ	Дүүргийн Засаг даргын 2013 оны 04 дүгээр захирамжаар Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн төвийн бүтэц орон тоог баталсан. Засаг даргын 2013 оны 365 дугаар захирамжаар 18 дугаар хорооны нутаг дэвсгэрт төвийн байр барих 0,025 га газрыг шийдвэрлэсэн.	90.0
115.		Хүүхэд, гэр бүлд зөвлөгөө өгөх төвүүдийг хороодод байгуулж, үйл ажиллагааг идэвхижүүлэх, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх	НХХ, ХГБХТ	19, 32 дугаар хороонд хүүхэд гэр бүлд зөвлөгөө өгөх нийгмийн ажилтны өрөөтэй болсон	90.0
116.	2.5.2	Гэр бүлийг дэмжих ажлыг зохион байгуулах	НХХ, ХГБХТ	Нийслэлийн Нийгмийн халамжийн үйлчилгээний газар, РР TV – тэй хамтран орон гэргүй, амьдрал хүнд сургууль завсардсан, тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхлэгч хүүхэдтэй 8-н өрхийн амьжиргааг дэмжих, аж ахуйн нэгж байгууллагын нийгмийн хариуцлагыг сайжруулах, нийгмийн зүгээс дэмжлэг үзүүлэх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор “Өөрчлөлт” бодит нэвтрүүлгийг зохион байгуулж байна. Нэвтрүүлэг 7 хоног бүр 1 удаа 2 давталттайгаар цацагдаж байна. Мөн TV-9 телевизтэй хамтран “Мөрөөдөл биелдэг юм” телевизийн нэвтрүүлгийг зохион байгуулж байна. Хүүхэд гэр бүл хөгжлийн төвийн албан хэрэгцээнд Японы Ве Forward олон улсын байгууллагаас Toyota Alphard маркын 12 хүний суудалтай автомашиныг хандивласан байна. “Үндэсний өгөх өдөр”-ийг Засаг даргын санаачилгаар бусад дүүргүүдийг уриалан өргөн хүрээтэйгээр тэмдэглэн өнгөрүүлээ. Нээлтийн ажиллагаанд дүүргийн удирдлага, БНСУ-ын Тэжон дүүргийн төлөөлөгчид болон дүүргийн иргэд хөдөлмөрчид оролцов. Үйл ажиллагааны үеэр эмзэг бүлгийн өрхийн 70 хүүхдэд дүрэмт хувцас, хичээлийн хэрэгсэл бэлэглэсэн. Тамгын газрын төрийн	90.0

				албан хаагчид цалингаасаа хандив өргөн дүүргийн нутаг дэвсгэрийн 50 гаруй усан сангаар иргэдэд үнэгүй ус түгээсэн байна. Жаргалант тосгоны Соёлын төвийн дугуйлангийн хүүхдүүд урлагийн тоглолт үзүүлж, эмнэлгийн анхан шатны үзлэг, оношилгоо хийн, цугласан хүмүүст халуун аарцаар үйлчлэх зэрэг үйл ажиллагааг зохион байгуулав. Нийт 40.8 сая төгрөгийн өглөгийг иргэддээ өгсөн болно.	
117.		Хороодын хамтарсан багийг чадавхижуулах сургалт сурталчилгааг зохион байгуулж, хамтарсан багийн ажлыг дүгнэх шалгуур үзүүлэлтийг боловсруулах	НХХ, ХГБХТ	Толгойт бүсийн хороодод /1-5, 20, 22, 32/ Дэлхийн зөн Монгол төрийн бус байгууллагын ТОНХХ-тэй хамтран хамтарсан багийг чадавхижуулах сургалтыг 4 удаа зохион байгуулсан.Хамтарсан багийн ажлыг дүгнэх шалгуур үзүүлэлтийг гаргаж хороодод хүргүүлэн ажилласан.	100.0
118.		Өсвөр үе, залуучуудад гэр бүлийн боловсрол олгох	НХХ	Дүүргийн Засаг даргын 184 дүгээр захирамжаар ажлын хэсэг байгуулан “Гэр бүлийн үнэ цэнэ” хэлэлцүүлгийг 2013 оны 05 сарын 09-ний өдөр хороодын ИНХ-ын дарга, Засаг дарга, нийгмийн ажилтнууд, иргэдийн төлөөллийн дунд зохион байгуулсан. Уг хэлэлцүүлгийг зохион байгуулахад нийт 1,6 сая төгрөгийг зарцуулсан. Хороод тус бүр иргэдийнхээ дунд “Гэр бүлийн үнэ цэнэ” сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулан, 960 иргэнийг судалгаанд хамруулан санал асуулга авч ажилласан. “Хүүхдээ эерэг аргаар хүмүүжүүлэх” сургалтыг 32 хороонд зохион байгуулж 750 иргэнийг хамруулсан.	100.0
119.		Хүчирхийлэлд өртсөн хохирогчдыг хамгаалах байр байгуулах ажлыг төрийн бус байгуулагуудтай хамтран хэрэгжүүлэх	ЗХХ, НХХ	Холт Олон Улсын хүүхдийн төлөө байгууллагаас дүүрэгт “Түр хамгаалах байр” байр барихаар харилцан тохирсон. Түр байрлуулан асрамжлах үйлчилгээг Хүчирхийллийн эсрэг үндэсний төвтэй 2013.01.01-ны өдрөөс эхлэн гэрээлэн ажиллаж байна. Тайлант хугацаанд нийт 11 иргэн хамрагдсан. Үүнээс хүнд нөхцөлд байгаа хүүхэд 6, хүчирхийлэлд өртсөн иргэн 5 байна. Гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах үйлчилгээг “Мон Харбор” ТББ -тай гэрээлэн ажиллаж байна.	90.0
120.	2.5.3	Хүнд нөхцөлд байгаа хүүхдийг асруулах, асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоох ажлыг зохион байгуулж хяналт тавих	НХХ	Хүнд нөхцөлд байгаа 85 иргэнд кейс нээн шаардлагатай тусламж үйлчилгээг хүргэн ажиллалаа. Нөхцөл байдлын үнэлгээг 85 гэр бүлд хийж, 20 хүүхдийг асрамж, сувиллын газар асруулж, 8 хүүхдийг гэр бүлд эргэн нэгтгэж, 57 хүүхдэд асран хамгаалагч,	100.0

				харгалзан дэмжигч тогтоолоо. Хүүхдийн халамж асрамжийн төвүүд болох Кристина нобел сангийн Нархан халамжийн төв, Эрдэм халамжийн төвийн үйл ажиллагаатай шалгаж, хүүхдийн бүртгэл явуулж, бичиг баримтын зөрчлийг арилгуулж ажилласан. Кристина нобел сангийн Нархан халамжийн төвд 50 хүүхэд, Эрдэм халамжийн төвд 18 хүүхэд хүмүүжиж байна. Эмзэг бүлгийн хүүхдүүдийг олж илрүүлэх, цаашид хандлагыг өөрчлөх, төлөвшүүлэх, холбон зуучлах, нөлөөллийн ажлуудыг дэс дараатайгаар зохион байгуулах зорилгоор 2013 оны 09 сарын 15-аас, 11 сарын 1-ний хооронд эрсдэлт бүлгийн хүүхдүүдийн судалгааг гаргасан. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны А/162 дугаар тогтоолоор гэмт хэргийн гэрч, хохирогч хүүхдийн эрх ашгийг хамгаалж, байцаан шийтгэх үйл ажиллагаанд оролцож байгаа насанд хүрээгүй хүмүүсийн эрхийг хүндэтгэх, тэдэнд нийгэм, эрх зүйн туслалцаа үзүүлэх зорилго бүхий дүүргийн “Хүүхдийн хууль зүйн хороо”-г байгуулаад байна.	
121.	Хүүхэд хамгаалал, нөлөөллийн төслийг Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлэх	НХХ, ХГБХТ	Хүүхэд хамгаалал, нөлөөллийн төслийг Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллагатай хамтран Толгойт бүсийн 8 хороонд хэрэгжүүлж байна. Нийт 200 өрхөд нийгмийн ажил үйлчилгээг хүргэн ажиллаж байна.	90.0	
122.	Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг эрхэлдэг хүүхдийг хөдөлмөрөөс хөндийрүүлэх арга хэмжээ авах	НХХ, ХГБХТ	Хогийн цэгт хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдийн 15 эцэг эхэд хүүхэд хүмүүжлийн зэрэг арга төлөвшүүлэх, зан үйлийг өөрчлөхөд чиглэсэн “Хүүхдийн ертөнц” 12 удаагийн багц сургалтыг 2013 оны 1 сарын 31 өдрөөс эхлэн 5 сарын 15 хүртэл долоо хоног бүрийн 4 дэх өдөр бүр зохион байгуулж ажиллалаа. Зорилтот бүлгийн 10 хүүхдэд зан үйлийг өөрчлөх, зөв дадал олгох “Амьдралд бэлэн” сургалтыг зохион байгуулсан. Мөн Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан хогийн цэгт хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүд, иргэдийн дунд өдөрлөг зохион байгуулсан.	100.0	
123.	Эмзэг бүлгийн өрхийн хүүхдийг зусланд амрах ажлыг зохион байгуулах	НХХ	Засаг даргын захирамжаар хөгжлийн бэрхшээлтэй эмзэг бүлгийн өрхийн 32 хүүхдийг Нарс зусланд үнэ төлбөргүй 7 хоног амруулсан.	100.0	
124.	Дүүрэгт хүүхдийн халамж асрамжийн төв байгуулах асуудлыг	НХХ, ХГБХТ	24 дүгээр хороонд Канад сангийн дэмжлэгтэйгээр хүүхдийн халамж асрамжийн өдөр өнжүүлэх төвийг 2013 оны 6 дугаар	50.0	

		холбогдох байгууллагуудад тавих		сарын 1-ний өдөр нээж, 50 хүүхэдтэйгээр үйл ажиллагааг явуулж байна. Дүүргийн Хүүхэд, гэр бүл, хөгжлийн төвийн мэргэжилтнүүд 2013 оны 08 дугаар сарын 16-нд Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг СОС хүүхдийн хотхоны төвийн үйл ажиллагаатай танилцаж туршлага судалсан.	
125.	2.5.4	Хүүхэд, залуучуудад хорт зуршил, мансууруулах бодисын хорт нөлөөг таниулах сургалт сурталчилгааг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах	НХХ, ХГБХТ	Хороодын нийгмийн ажилтнууд ерөнхий боловсролын сургууль, Цагдаагийн 1, 2 дугаар хэлтэстэй хамтран архи тамхины хор уршгийг таниулах, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх сургалтыг 620 сурагчдад зохион байгуулсан.	70.0
126.		Цахим тоглоомын газар, интернет төвүүдийн үйл ажиллагаанд холбогдох байгууллагуудтай хамтран хяналт тавих, стандартыг мөрдүүлэх	НХХ, ХГБХТ, ЦХ I, II, МХХ	Дүүргийн 90 гаруй интернэт, цахим тоглоомын газар үйл ажиллагаа явуулж байгаагаас 30 гаруй интернет кафе эзэдтэй уулзалт хийж, хамтран ажиллаж байна. Интернет кафе, цахим тоглоомын газрын үйлчилгээг зохицуулах нийтлэг журмыг боловсруулан Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн.	100.0
127.	2.5.5	Нийгмийн ажилтнуудыг хүүхдийн эрх, хөгжил, хамгааллын чиглэлээр сургалтанд хамруулах	НХХ, ХГБХТ	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоотой хамтран “Хөгжлийн бэрхшээлийг ойлгох нь” сургалтыг 2013 оны 2 дугаар сарын 4-ний өдөр зохион байгууллаа. Сургалтанд 1, 3, 10, 23, 24, 31 дүгээр хорооны нийгмийн ажилтан, халамжийн мэргэжилтэн, өрхийн эмч нар хамрагдлаа. Хорооны нийгмийн ажилтнуудад “Нийгмийн ажил” сургалтыг 2013 оны 2 сарын 25-ны өдөр зохион байгууллаа. Энэхүү сургалт нь хороодын нийгмийн ажилтнуудын олон нийттэй ажиллах нийгмийн ажлын арга зүй, онолын мэдлэгийг бататгасан сургалт болсон. “Өрхийн сургалт үнэлгээ” сургалтыг хороодын нийгмийн ажилтнуудад 5-р сарын 4-ны өдөр зохион байгуулсан. Олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан хороодод гэр бүлийн хэлэлцүүлэг, гэрийн хурал, гэр бүлийн уулзалт, зөвлөгөөн зохион байгуулах тухай зөвлөмж чиглэл өгч ажилласан. Нийслэлийн хүүхэд гэр бүл хөгжлийн газраас Хороодын нийгмийн ажилтнуудын чадавх бэхжүүлэх сургалтыг 2013 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр зохион байгууллаа. Сургалтын үйл ажиллагаанд нийт 868,0 мянган төгрөг зарцуулсан.	100.0
128.		Нийгмийн ажилтнуудын дунд онол практикийн бага хурал зохион байгуулах	НХХ, ХГБХТ	Олон улсын гэр бүлийн өдрийг угтан нийгмийн ажилтнуудын дунд “Гэр бүлийн үнэ цэнэ” илтгэлийн уралдааныг зохион байгуулж, тэргүүн байранд 27 дугаар хорооны нийгмийн ажилтан	100.0



				О.Ариунжаргал, дэд байранд 6 дугаар хорооны нийгмийн ажилтан А.Бямба нар шалгарсан.																															
<b>Гурав: Иргэдийн ая тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.</b>																																			
<b>3.1. Дэд бүтэц</b>																																			
129.	3.1.1	Орон сууцны барилгуудын инженерийн гадна, дотор шугам сүлжээг сайжруулах ажлыг үргэлжлүүлэх	ДБТХ	13 дугаар хорооны 11 дүгээр байрны оруулгын 50у/м 5 хос шугам. 12, 13, 14 дүгээр хорооны орон сууцны 5,11,12,13, 14 дүгээр байрны хэрэгцээний халуун усны дотор системийн ф 32-Ф100 мм 103 у/м шугамыг хэсэгчлэн, 112-р цэцэрлэгээс контор хүртэлх хэрэгцээний халуун, хүйтэн усны ф 50 мм 60 у/м гадна шугам, 19 дүгээр хорооны 21 дүгээр хорооллын орон сууцны халаалтыг сайжруулах зорилгоор ф50-Ф150мм 731,4 у/м шугам, 15 дугаар хорооны 19,20 дугаар байрны дундах Ф80-Ф100мм 240 у/м шугам, 18-р хорооны угсармалын 7 дугаар байрнаас 5, 12 дугаар байр хүртэл гадна дулаан, ус хангамжийн шугамыг тус тус шинэчлэн сольсон. 21-р хороо Жаргалант тосгоны Захирагчийн ажлын албаны гаднах 173 у/м шугам сүлжээний шинэчлэлтийг “Бөртө” ХХК 58,0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн.Ханын материалын бохирын шугамын өргөтгөл шинэчлэлийн ажлыг нийт 146.0 сая төгрөгийн санхүүжилтээр “Бумбод” ХХК хийж гүйцэтгэсэн. Дүүргийн 65 дугаар сургуулийн гадна дулааны шугам солих ажлыг нийт 46,8 тэрбум төгрөгийн санхүүжилтээр “Болор таун” ХХК хийж гүйцэтгэсэн.	100.0																														
130.		1-р хорооллын 12-р байрны шугам сүлжээг хонгилын системд шилжүүлэх	ДБТХ	Нийслэлийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 1 дүгээр хорооллын 12-р байрны шугам сүлжээг хонгилын системд шилжүүлэх ажлын зураг, төсөв хийгдсэн.	30.0																														
131.	3.1.2	Орон сууцны хорооллын байрны дээвэр болон цахилгаан шатыг засварлаж шинэчлэх ажлыг үргэлжлүүлэх	ДБТХ	Нийслэлийн хөрөнгө оруулалтаар дараах орон сууцны байрны дээврийн засварын ажил хийгдсэн. Үүнд : <table border="1" data-bbox="926 1101 1774 1330"> <thead> <tr> <th>д/д</th> <th>Хо-роо</th> <th>СӨХ-ийн оноосон нэр</th> <th>Байрны дугаар</th> <th>Талбайн хэмжээ м<sup>2</sup></th> <th>Өртөг /сая төг/</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>6</td> <td>Гэрэлт цом</td> <td>58а</td> <td>860</td> <td>46,7</td> </tr> <tr> <td>2</td> <td>6</td> <td>Гэрэлт цом</td> <td>58б</td> <td>860</td> <td>46,7</td> </tr> <tr> <td>3</td> <td>14</td> <td>Өнөр 12</td> <td>12а</td> <td>600</td> <td>36,5</td> </tr> <tr> <td>4</td> <td>14</td> <td>Өнөр 15</td> <td>15</td> <td>362</td> <td>20,0</td> </tr> </tbody> </table>	д/д	Хо-роо	СӨХ-ийн оноосон нэр	Байрны дугаар	Талбайн хэмжээ м <sup>2</sup>	Өртөг /сая төг/	1	6	Гэрэлт цом	58а	860	46,7	2	6	Гэрэлт цом	58б	860	46,7	3	14	Өнөр 12	12а	600	36,5	4	14	Өнөр 15	15	362	20,0	100.0
д/д	Хо-роо	СӨХ-ийн оноосон нэр	Байрны дугаар	Талбайн хэмжээ м <sup>2</sup>	Өртөг /сая төг/																														
1	6	Гэрэлт цом	58а	860	46,7																														
2	6	Гэрэлт цом	58б	860	46,7																														
3	14	Өнөр 12	12а	600	36,5																														
4	14	Өнөр 15	15	362	20,0																														

				5	15	Өнөр 19	19-6, 11, 12-р орц	1122	61,7		
				6	16	Өнөр 324	25	1428	79,1		
				7	16	Соёлт	30	362	19,5		
				8	17	Бат холбоо	32	1050	57,7		
				9	17	Өргөө 33	33-1, 4, 5, 6- р орц	1400	82,2		
				10	18	Мөнх тулга	27	330	18,1		
				11	18	Мөнгөн цом	10	822	45,6		
				12	18	Мөнхмандах	3	884	50,1		
				13	18	Их мандал	7	884	51,0		
				14	19	Од	2-58	820	43,0		
				15	19	Тулга 21	2-60	824,4	49,9		
				16	19	Тохилог 21	46	952	51,4		
				17	19	Сүрлэг 21	8а	1785	59,5		
				18	20	Хотхон 8	8	400	22,0		
				<b>ДҮН</b>					<b>15181</b>	<b>844,8</b>	
				<p>Нийслэлийн хөрөнгө оруулалтаар :</p> <p>-12 дугаар хороо Итгэл 1 СӨХ-ны 1 дүгээр байрны 3 дугаар орцны цахилгаан шат 40,5 сая төгрөгөөр,</p> <p>- 12 дугаар хороо Өнөр 2 СӨХ-ны 2 дугаар байрны 10 дугаар орцны цахилгаан шат 40,5 сая төгрөгөөр, нийт 2 цахилгаан шатыг 81.0 сая төгрөгөөр шинээр угсарсан.</p>							
132.	3.1.3	22-ын товчоо чиглэлийн 10,6 км авто замын өргөтгөл шинэчлэлтийн ажлыг үргэлжлүүлэх	ДБТХ	22-ын товчоо чиглэлийн 10,6 км авто замын өргөтгөл шинэчлэлтийн ажлыг “Бэрх зараа” ХХК гүйцэтгэж байна. /1.0 тэрбум төгрөг/							90.0
133.		СХД, 25-р хороо, Зүүн салааны 3.6 км авто замыг шинэчилж, шинээр 1.2 км авто зам үргэлжлүүлэн барих	ДБТХ	25 дугаар хороо, Зүүн салааны 3.6 км авто замыг засварлах, шинээр 1.2 км авто зам шинэчлэх ажлыг нийт 3,2 тэрбум төгрөгийн санхүүжилтээр “ОДНД” ХХК гүйцэтгэсэн.							100.0
134.		Баруун салааны 4.1 км авто зам, 18.64+27.68 м гүүрийн барилгын ажлыг үргэлжлүүлэн дуусгах	ДБТХ	Баруун салааны 4.1 км авто зам, 18.64x27.68 м гүүрийн барилгын ажлыг нийт 4,1 тэрбум төгрөгийн санхүүжилтээр “Хотын зам” -ХХК гүйцэтгэсэн.							100.0
135.		Орбит-Тахилтын 7.1 км авто зам, гүүрийн барилгын ажлыг	ДБТХ	Орбит-Тахилтын 7.1 км авто зам, гүүрийн барилгын ажлыг 6,4 тэрбум төгрөгийн санхүүжилтээр Хурдны зам ХХК гүйцэтгэсэн.							100.0

	үргэлжлүүлэн дуусгах			
136.	Нийтийн эзэмшлийн болон орон сууц, гэр хорооллын доторх авто зам, гүүрийг шинээр тавих, засварлах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх	ДБТХ	Толгойт, Нарангийн гол, Их наран, Орбит, Найрамдал, Улаан чулуутын чиглэлийн авто замын 3000м <sup>2</sup> талбайн авто замын нөхөөс тавих урсгал засварын ажлыг “Цүүрдэн”, “Цогт зам” ХХК –иуд 141,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн. 21 дүгээр хороо Жаргалант тосгоныг Дархан-Сэлэнгийн чиглэлийн авто замтай холбох 17,8 км шинэ автозамын ажлыг “Төгс зам”, “Бат-кубик” ХХК-ууд хийж гүйцэтгэн хүлээлгэн өгч ашиглалтанд оруулсан. 31 дүгээр хорооны гэр хорооллын 270м авто зам, 19 дүгээр хорооны 100 м авто замыг тус тус засварласан. Нийт 269,0 сая төгрөгний ажлыг хийж гүйцэтгэсэн.	100.0
137.	Хангай зах орчмын 4.8 км үерийн хамгаалалтын байгууламжийн ажлыг үргэлжлүүлэх	ДБТХ	Хангай зах орчмын 4.8 км үерийн хамгаалалтын байгууламжийн ажлыг 990.0 сая төгрөгийн санхүүжилтээр Хүчит чулууХХК гүйцэтгэж, нийслэлийн хөрөнгө оруулалтын газарт хүлээлгэн өгсөн.	100.0
138.	Энхтайваны өргөн чөлөөнөөс МИК руу өгсөх замд ус зайлуулах хоолой шинээр байгуулах асуудлыг судлан холбогдох байгууллагуудад хандах	ДБТХ	Нийслэлийн авто замын газарт Москвагийн гудамжаас Мах Импекс компани өгсөх замд ус зайлуулах хоолой шинээр байгуулах хөрөнгө оруулалтын асуудлаар Засаг даргын Тамгын газрын 3/264, 3/1075 дугаар албан бичгээр хүсэлтээ уламжилсан.	100.0
139.	Мон-лааны гудамжийг үерийн уснаас хамгаалах, далан барих асуудлыг холбогдох байгууллагуудад уламжлах	ДБТХ	7-р хорооны Мон-лааны гудамжийг үерийн уснаас хамгаалах, далан барих хөрөнгийн асуудлыг шийдүүлэхээр Нийслэлийн Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтэст Засаг даргын Тамгын газрын 3/1144 албан бичгээр хүсэлт гарган уламжилж, 2014 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахаар болсон.	100.0
140.	Махын 1-30 байранд үерийн ус зайлуулах хоолой угсрах асуудлыг судлан холбогдох байгууллагуудад хандах	ДБТХ	Нийслэлийн Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтэст Засаг даргын Тамгын газрын 3/1144 албан бичгээр хүсэлт гарган уламжилж, 2014 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахаар болсон.	100.0
141.	Үйлдвэрчний эвлэлийн гудамжны Баянхошуу чиглэлийн 3.4 км авто замын өргөтгөл шинэчлэлтийн ажлыг дуусгах	ДБТХ	Ханын материал, Баянхошуу руу салдаг уулзвараас Баянхошууны хуучин эцэс хүртэлх автозамыг нийт 7,2 тэрбум төгрөгийн санхүүжилтээр Хувай Монголиа ХХК бүрэн гүйцэтгэсэн. Үйлдвэрчний эвлэлийн гудамжны авто замын өргөтгөл шинэчлэлтийн ажил хойшлогдож 2014 онд хийхээр болсон.	70.0
142.	Буяны 2.6 км авто замыг дуусгах /2, 3, 26-р хороо/	ДБТХ	Буяны 2.6 км авто замын ажлыг 1,6 тэрбум төгрөгийн санхүүжилтээр Мичид-ХХК гүйцэтгэсэн. /2, 3, 26-р хороо/	100.0

143.		Гэмтлийн эмнэлгийн замаас баруун тийш 1-р хорооллын арын авто замтай холбогдох 1.2 км авто замын ажлыг дуусгах	ДБТХ	Гэмтлийн эмнэлгийн замаас баруун тийш 1 дүгээр хорооллын арын авто замтай холбогдох 1.2 км авто замын ажлыг 1,2 тэрбум төгрөгийн санхүүжилтээр “Экспресс зам” ХХК гүйцэтгэсэн.	100.0
144.	3.1.4	Шаардлагатай бэлтгэл ажлыг хангах	ДБТХ, ӨГХА	Баянгол дүүргийн 3 дугаар хорооллын Ард Аюушийн гудамжийг дүүргийн 23, 30, 31 дүгээр хороодын нутаг дэвсгэрээр дамжуулан 19, 27 дүгээр хороодын нутаг дэвсгэр дэх Үйлдвэрчний эвлэлийн гудамжтай холбох 3,1 км авто зам, 6 гүүрийн хамт баригдах автозамын трасст орсон 229 нэгж талбар, 100 байшингийн хөрөнгийн үнэлгээ, хөрөнгийн бүтэц, ангилалд судалгаа, үнэлгээ хийх ажил өмнөх жилүүдэд хийгдсэн. 2014 онд Засгийн газраас хэрэгжүүлж буй “Гудамж” төслийн хүрээнд авто замын ажлыг үргэлжлүүлэн хийхээр төлөвлөөд байна.	-
145.	3.1.5	19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах 3-48 айлын байрыг буулгаж, барилгын ажлыг эхлүүлэх	ДБТХ	19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах 3-48 айлын байрыг буулгаж, барилгын ажлыг “Номтын-ам” ХХК гүйцэтгэж байна.	100.0
146.		20-р хорооны Хуучин цэргийн хотхон, Хангамж, 1, 5-р баазын ажилчдын байр, Төмөр замын дан байруудыг “Цэргийн хотхон” орон сууцны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу орон сууцжуулах ажлыг эхлүүлэх	ДБТХ, ЭЗТХ	Нийслэлийн Ерөнхий төлөвөгөөний газарт 1/1017 дугаар албан бичгээр уламжилж, “Цэргийн хотхон” орон сууцны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу орон сууцжуулах ажил 20 дугаар хорооны Хуучин цэргийн хотхоны дан байруудын айл өрхийн 80%-нь зөвшөөрсөнөөр уг газарт Чогсэрд-ХХК хашаа татаж, улаан шугам тавих ажил хийгдсэн. Ажлын зураг төсөв гаргаж батлуулсан. Нийслэлийн ерөнхий төлөвлөгөөний газарт барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл авахаар хүсэлт гаргасан.	50.0
147.	3.1.6	Дахин төлөвлөлт хийгдсэн гэр хороололд инженерийн дэд бүтцийг бий болгох чиглэлээр нийслэлийн Захирагчийн албаны дүүрэг дэх албадтай хамтран ажиллах	ДБТХ, ЭЗТХ	Гэр хорооллын дахин төлөвлөлттэй уялдуулан Хангай захаас Ханын материалын эцэс хүртэл 4км газарт Ф400 мм-ын дулааны шугамыг шинээр суурилуулах ажлыг “Есөн талст оргил” ХХК гүйцэтгэж байна. Барилгын эскиз зураг батлагдсан ба ажлын зураг батлагдахаар хүлээгдэж байна. Мөн инженерийн дэд бүтцийг бий болгох ажлын хүрээнд хийгдэж байгаа судалгаа болон Дэд бүтцийг бий болгох ажлыг иргэд олон нийтэд мэдээллэх ажилд Нийслэлийн Захирагчийн албаны дүүрэг дэх албадтай хамтран нийт 5866 өрхийг хамруулан олон талт судалгаа авч нэгтгэсэн, 21 удаа иргэдтэй уулзалт хийж идэвхижүүлж ажиллсан байна. Дүүргийн 30-р хороо Хилчин хотхон орчмын нийт 168 өрхийг инженерийн шугам сүлжээнд	90.0

				холбох ажлыг улсын төсвийн 5 тэрбум төгрөгийн хөрөнгөөр батлагдсан зураг төсвийн дагуу АТМОР ХХК гүйцэтгэж байна. Баянголын амны орон сууцны хорооллын дулааны шугам татах ажил хийгдэж байна.	
148.	3.1.7	2, 7, 9, 21, 22, 23, 24, 25, 26, 28, 30, 31, 32-р хороодод худаг, усан сан барих ажлыг иргэдийн саналыг авч зохион байгуулах	ДБТХ	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 1, 2, 3, 6, 7, 21, 22, 23, 24, 25, 26, 28, 30, 31, 32 дугаар хорооны нутаг дэвсгэрт худаг, усан сан барихаар дүүргийн Засаг даргын 297 дугаар захирамжаар газрын байршлыг шийдвэрлэн Тамгын газрын даргын 3/1051 тоот албан бичгээр техникийн нөхцөл гаргуулахаар Ус сувгийн удирдах газарт хандсан боловч 3 байршилд зөвшөөрсөн. 1-р хорооны Толгойтын 107-108 дугаар гудамж, 2-р хорооны 72 дугаар гудамжны баруун талд, 25-р хорооны Одонтын 12 дугаар гудамжинд, 28-р хорооны Ногоон чулуутын 9-34 тоотын өмнө усан сан, 32 дугаар хорооны цогцолбор байрны хажууд гүний худаг, Нийслэлийн хөрөнгө оруулалтаар 11 дүгээр хорооны АОС-ны 3 дугаар гудамжны 76А тоотын зүүн талд, 32 дугаар хорооны Баруун турууны энгэр 8 дугаар гудамжны 16 тоотын өмнө тус тус 1 усан сан барих, 32 дугаар хорооны Мал бордоход гүний худаг гаргах ажлууд хийгдэж дууссан. 9 дүгээр хорооны Зүүн салааны 8 дугаар гудамжинд Тайваны хүүхэд, гэр бүлийг дэмжих сан”гийн хөрөнгө оруулалтаар /26,0 сая,төг/ усан сан баригдсан.	50.0
149.	3.1.8	5, 6, 7, 10, 21, 24, 26, 30, 32-р хороодын эрчим хүчгүй айл өрхийн судалгааг шинэчлэн гаргаж, шинээр холбох, хүчдэл сайжруулах	ДБТХ	3 дугаар хорооны Бага нарангийн 44-47 гудамж, 8 дугаар хорооны Баянцагааны 3-6, 10 дугаар гудамж, АТП 543-ын ачаалал хөнгөлөх, шинээр дэд станц барих ажил, 9 дүгээр хорооны Баруун баян уул АТП-422-ын дэргэд шинээр дэд станц барих, 23 дугаар хорооны Хангайн гудамж АТП-1664-ын 0.4 кВ-ын ЦДАШ-ын шинэчлэлтийн ажил, 24 дүгээр хорооны Зээлийн гудамжны айл өрхүүдийг цахилгаан эрчим хүчээр хангах ажил, 7, 23, 24 дүгээр хорооны гэр хорооллын айл өрхүүдийг цахилгаан эрчим хүчээр хангах, хүчдэл сайжруулах ажлууд хийгдсэн	70.0
150.	3.1.9	Гэр хорооллыг инженерийн шугам сүлжээнд холбох эхний ээлжийн байршлуудад оршин суугчдын санал авах ажлыг зохион байгуулах	ДБТХ, ЭЗТХ	Нийслэлийн гэр хороолол, орон сууцжуулах төсөлтэй хамтран гэр хорооллын дахин төлөвлөлтийн талаар 10 хорооны /1, 2, 3, 4, 8, 23, 24, 25, 26, 27/ 5866 өрхийг хамруулан судалгаа явуулахад өмчлөл, эзэмшлийн газраа орон сууцаар солих-37.3%, инженерийн шугам, сүлжээ татуулах-31.8, худалдах-2,7,	100.0

				шийдээгүй-20.6, хариулаагүй-7.7 гэсэн үр дүн гарсан байна.	
151.	3.1.10	Гэр хороололд ахуйн үйлчилгээний цэг салбарын тоог нэмэгдүүлэх	ДБТХ	2 дугаар хорооны нутаг дэвсгэрт Орбитын 1 дүгээр гудамжны 4 тоотод иргэн Д.Даваа өөрийн хөрөнгөөр барилга барьж халуун ус, сауны зориулалтаар үйлчилгээ үзүүлэх хүсэлт ирүүлснийг дэмжин ажиллаж байна. НҮБ-ын “Хабитат” төслийн хүрээнд 30,31 дүгээр хорооны нутаг дэвсгэрт ахуй үйлчилгээний цогцолбор баригдаж ашиглалтанд орсон.	90.0
152.	3.1.11	Тахилт,Толгойт, Баруун салаа, Зүүн салаа, 1-р хорооллын арын дэнжийн чиглэлд үйлчлэх нийтийн тээврийн үйлчилгээний автобусын тоог нэмэгдүүлж, зогсоолыг тохижуулах	ДБТХ	Тахилтын чиглэлд том оврын 9 автобус /том оврын автобус үйлчилдэггүй байсан/, Баруун салаанаас Баянхошуу хойгуур ажлын өдөр 13 /урд нь 9 автобустай байсан/, урдуур 6, амралтын өдөр 4 том оврын автобус шугамаа уртасган Наран туул зах хүртэл үйлчилж байна. Зүүн салааны чиглэлд том оврын автобусны 1 ээлжийн үйлчилгээг 2 ээлж болгож нийтийн тээврийн том оврын автобусны тоог нэмэгдүүлсэн.	100.0
153.	3.1.12	Саппорогийн аюулгүй тойрог дээрх авто замын нэвтрүүлэх чадварыг дээшлүүлэн, замын сүлжээний өргөтгөл хийж, давхар зам шинээр барих ажлыг эхлүүлэх	ДБТХ	“Гудамж” төслийн хүрээнд Саппорогийн тойргийг дөрвөн замын уулзвар болгох ажлын зураг төслийг “Танил санаа” ХХК, зам барилгын ажлыг “Наранбулаг Хан” ХХК гүйцэтгэсэн.	100.0
154.	3.1.13	Сонсголонгийн авто зам ба гүүрийн өргөтгөл шинэчлэлтийг эхлүүлэх	ДБТХ	Сонсголонгийн авто зам ба гүүрийн өргөтгөл шинэчлэлтийн ажлыг “Мандах ойл”ХХК гүйцэтгэж байна.	100.0
<b>3.2. Тохижилт</b>					
155.	3.2.1	8, 9,11, 12, 13, 19, 20, 21, 22, 24, 28, 30-р хороодод иргэдийн саналыг нь авч хүүхдийн тоглоомын талбай байгуулах	ДБТХ	Нийслэлийн хөрөнгө оруулалтаар 14 хорооны 19 байршилд нийт 2,240 тэрбум төгрөгийн санхүүжилтээр хүүхдийн тоглоомын талбай ашиглалтанд оруулсан. 9, 10, 11, 19, 21, 22, 23, 30 дугаар хороодод хүүхдийн тоглоомын талбай байгуулахаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан.27-р хороонд тоглоомын талбай барихаар тендерийн материал хүлээн авч байна. 13 дугаар хорооны 11 байрны 1-р орцны урд талбайд “Фроцоцэ”ХХК 64.7 сая төгрөгийн төсөвт өртөгөөр тоглоомын талбайн тохижилт хийж хүлээлгэн өгсөн. 24 дүгээр хорооны зээлийн 4 дүгээр гудамжинд “СБМ”ХХК 43.5 сая төгрөгийн төсөвт өртгөөр хийж хүлээлгэн өгсөн.	70.0
156.		2-р хороонд /42-р сургууль/ хөлбөмбөгийн, 8, 11, 12, 26, 30-р хороодод иргэдийн саналыг авч	ДБТХ	2 дугаар хорооны /42- дугаар сургууль / хөл бөмбөгийн талбай байгуулахаар тендер зарлан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан. 17 дугаар хорооны 32, 33 дугаар байрны дунд	50.0

	сагсан бөмбөгийн талбай байгуулах		сагсан бөмбөгийн талбайг хашаажуулж, сандал тавьж тохижуулах ажлыг “Татах агаар”ХХК 24.6 сая төгрөгийн төсөвт өртөгөөр гүйцэтгэж хүлээлгэн өгсөн. 18, 31 хороонд он дамжин хийгдэж байгаа сагсан бөмбөгийн талбай байгуулах ажлыг “Ар дааган”ХХК 2013 оны 11 дүгээр сарын 11-ны өдөр хүлээлгэн өгсөн. 8, 11, 12, 26, 30 дугаар хороодод сагсан бөмбөгийн талбай байгуулах тохижилтын ажил төсөв хүрээгүй учраас хойшлогдсон.	
157.	8, 12, 18, 20, 28, 29, 30, 31-р хороодод иргэдийн саналыг нь авч бичил цэцэрлэг байгуулж, тохижуулах	ДБТХ	1, 3, 29 дүгээр хороодод орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бичил цэцэрлэг байгуулах ажил үндсэндээ дууссан бөгөөд мод тарих ажлыг 2014 оны хавар хийнэ. 20 дугаар хорооны тээвэрчдийн 20 айлын байрны урдах талбайд “Ургах тэмүүлэл”ХХК 29.9 сая төгрөгийн төсөвт өртөгөөр бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулан хүлээлгэн өгсөн. 8, 12, 18-р хороодод иргэдээс санал ирээгүй ба 28, 30, 31 дүгээр хороодод байгуулах бичил цэцэрлэг төсөв хөрөнгө хүрэлцээгүй учраас хойшлогдсон.	50.0
158.	18, 19-р хороодод усан оргилуур бүхий иргэдийн чөлөөт цагийг өнгөрүүлэх талбай байгуулж тохижуулах	ДБТХ	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 18, 19-р хороодод усан оргилуур бүхий иргэдийн чөлөөт цагийг өнгөрүүлэх талбай байгуулахаар төлөвлөгдсөн боловч төсөв хүрэлцэхгүйн улмаас хойшлогдсон.	-
159.	Толгойт, Зүүн салааны автобусны эцсийн буудал, Ханын материал, 1-р хорооллын Саппоро үйлчилгээний төв, 8-р хороо Нуурын орчимд нийтийн бие засах газар байгуулах	ДБТХ	12 дугаар хорооны Саппоро үйлчилгээний зүүн талд, 29 дүгээр хорооны “Арвижих” цайны газрын зүүн талд нийтийн бие засах газрыг нийслэлийн төсвөөс санхүүжүүлэн байгуулахаар газар шорооны ажил хийгдэж байна. Тус 3 хорооны нутаг дэвсгэр дээр нийтийн бие засах газар барих гүйцэтгэлийн ажлыг “Дэлгэр констракшн” ХХК 336.0 сая төгрөгийн санхүүжилтээр хийж гүйцэтгэхээр болсон. Баянхошууны эцэст нийтийн бие засах газрыг “Аж Богд Моунте” ХХК 179.0 сая төгрөгийн төсөвт өртөгөөр хийж гүйцэтгэхээр шалгарч газар шорооны ажил хийгдэж байна. 24-р хороонд баригдах нийтийн бие засах газрын техникийн нөхцөл гаргах ажил хийгдэж байна.	50.0
160.	2, 4, 9, 22, 28, 30, 32-р хороодод иргэдийн саналыг авч явган хүний зам барих, засварлах	ДБТХ	2-р хороонд явган хүний зам барих ажлын тендерийн бичиг баримт боловсруулах ажил хийгдэж, 30-р хороонд явган хүний зам барих ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан. 9, 22, 28, 32-р хороодод төсөв хүрэлцэхгүйн улмаас хойшлогдсон.4 дүгээр хорооны Их нарангийн 7, 8 дугаар	50.0

				гудамжинд 350 м2 явган хүний замыг “СБМ” ХХК 22 сая төгрөгийн төсөвт өртөгөөр хийж гүйцэтгэсэн. 5 дугаар хорооны Баянголын 16, 17 дугаар гудамж 18 дугаар гудамжуудад 450 м2 явган хүний замыг “СБМ” ХХК 26 сая төгрөгийн төсөвт өртөгөөр тус тус хийж гүйцэтгэж хүлээлгэн өгсөн.	
161.		2, 24, 26, 28-р хороодод иргэдийн саналыг авч явган хүний гүүр барих	ДБТХ	24 дүгээр хороонд явган хүний гүүр барихаар газар шорооны ажил хийгдэж байна. 26-р хорооны Алтан овоо 1-6 гудамж, Мандал овоо 24 дүгээр гудамж, Мандал овоо 30-31 дүгээр гудамжуудад “Ану холдинг” ХХК нийтдээ 75.0 сая төгрөгийн төсөвт өртөгөөр хийж гүйцэтгэн ашиглалтанд оруулаад байна. 2, 28-р хороодод төсөв хүрэлцээгүй учраас хойшлогдсон.	70.0
162.		27 дугаар хорооны Агарын 3 дугаар гудамжийг явган хүний зам, гэрэлтүүлэг бүхий байдлаар тохижуулах	ДБТХ	Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 30.0 сая төгрөгийн хөрөнгөөр явган хүний зам, гэрэлтүүлэг бүхий тохижилтын ажлын тендерийн бичиг баримт боловсруулж байна.	30.0
163.	3.2.2	Энхтайваны өргөн чөлөө, Үйлдвэрчний эвлэлийн гудамжийг иж бүрэн тохижуулах	ДБТХ	Энхтайваны өргөн чөлөө буюу Москвагийн гудамжны иж бүрэн тохижилтыг “Тотал-Инж”ХХК хийж бүрэн гүйцэтгэсэн. Ханын материалаас Баян хошууны тойрог хүртэлх явган хүний зам, гэрэлтүүлгийг “Хувай Монголиа”ХХК 921.0 сая төгрөгөөр бүрэн хийж гүйцэтгэсэн.	70.0
164.		Хүй долоон худаг морь барианы газарт үйлчилгээний цэгүүдийн байрлах орчныг тохижуулах	ДБТХ	Хүй долоон худгийн морь барианы газарт үйлчилгээний цэгүүдийн байрлах орчныг тохижуулан, Хуушуурын гэр барих талбай болон урлагийн наадмын талбайг бетондож, Эко хавтан бүхий авто зогсоол байгуулсан. Био жорлон 24 ширхгийг суурилуулан, 200 хогийн савыг байрлуулах бэлтгэл ажил хангагдсан.	100.0
165.		22-ын товчооны шалган нэвтрүүлэх байрыг ашиглалтанд оруулах	ДБТХ	Нийслэлийн төсвийн 500,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Сант Хаан” ХХК 22-ын товчооны шалган нэвтрүүлэх байрыг барьж ажил дууссан.	100.0
166.	3.2.3	Авто замын гэрэлтүүлгийн 80 хувийг эрчим хүчний хэмнэлттэй, дэвшилтэт технологи бүхий LED гэрлээр солих	ДБТХ	Москвагийн гудамжны 300 ш, Үйлдвэрчний эвлэлийн гудамжны 200 ш, Зүүн салааны авто замын 156 ш гэрэлтүүлгийг LED гэрлээр сольсон. Нийтийн эзэмшлийн зам талбайн гэрэлтүүлгийн 47.1 хувийг LED гэрэлтэй болсон.	70.0
167.		Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар Нефтийн уулзвараас Орбит хүртэлх, Залуус, Барилгачин гудамжны нийтийн эзэмшлийн зам	ДБТХ	“Электрит ком” ХХК нийслэлийн төсвийн хөрөнгөөр гэр хороололд 246.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 280 ширхэг гэрэлтүүлгийг хүлээлгэн өгч ашиглалтанд оруулсан. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар Нефтийн уулзвараас Орбит хүртэлх нийтийн	70.0



	талбайд198 ш, 2, 4, 26-р хороодод 340 ш, 6, 13, 14, 16, 20-р хороодын орон сууцны хороололд 82 ш, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 3, 5, 8, 9, 10, 11, 18, 21, 22, 23, 25, 26, 28-32-р хороодод иргэдийн саналыг авч гэрэл шинээр тавьж, засвар үйлчилгээг гүйцэтгэх		эзэмшлийн зам талбайд 199 сая, 13-р хорооны Залуус гудамжинд 35.6 сая, 15-р хорооны Барилгачин гудамжинд 32.4 сая төгрөгийн гэрэлтүүлгийн ажил гүйцэтгэх сонгон шалгаруулалтыг хийж гэрээ байгуулах шатандаа байна. 4-р хорооны гэр хороололын гудамжинд 190 сая төгрөгийн, 26-р хорооны гэр хорооллын гудамжинд 274.5 сая төгрөгийн, 6-р хорооны орон сууцны хороолол дотор 34.5 сая, 13-р хорооны орон сууцны хороолол дотор 35.6 сая, 15-р хорооны орон сууцны хороолол дотор 32.4 сая, 16-р хорооны орон сууцны хороолол дотор 57.3 сая, 20-р хорооны орон сууцны хороолол дотор 74.1 сая төгрөгийн гэрэлтүүлэг хийх ажлын сонгон шалгаруулалт хийгдэж гэрээ байгуулах шатандаа байна. Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 1-р хороонд 61.6 сая, 2-р хороонд 23.1 сая, 3-р хороонд 78.4 сая, 4-р хороонд 70 сая, 5-р хороонд 58.6 сая, 6-р хороонд 49.6 сая 7-р хороонд 71.0 сая, 8-р хороонд 101.9 сая, 9-хороонд 48.7 сая, 10-р хороонд 68.1 сая, 11-р хороонд 63 сая, 22-р хороонд 51.3 сая, 23-р хороонд 49.4 сая, 24-р хороонд 45 сая, 25-р хороонд 30.7 сая, 26-р хороонд 31 сая, 28-р хороонд 20 сая, 30-р хороонд 14.7 сая нийт <b>936.1</b> сая төгрөгийн гэрэлтүүлгийн ажлын зураг, төсөл батлагдах шатанд байна. 16-р хорооны орон сууцны дунд 34.2 сая, 17-р хорооны орон сууцны дунд 23 сая, 18-р хорооны орон сууцны дунд 10 сая нийт <b>67.2</b> сая төгрөгийн гэрэлтүүлэгийн зураг, төсөв батлагдах шатанд байна.	
168.	Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй байгууллага, аж ахуйн нэгжийг орчин үеийн шийдвэр бүхий өнгө үзэмжтэй гэрэлтүүлэгтэй болгох ажлыг зохион байгуулах	ДБТХ	Дүүргийн Засаг даргаас нутаг дэвсгэрийн 157 Аж ахуйн нэгж байгууллагад тохижилтын ажлын талаар өгсөн албан даалгаварт орчин үеийн шийдэл бүхий өнгө үзэмжтэй гэрэлтүүлэгтэй болох заалт оруулсан. Дүүргийн нутаг дэвсгэрийн гол авто замуудын дагуу байрлалтай ААНБ-ын 80 гаруй хувийн гадна гэрэлтүүлэг чимэглэлийн өнгө үзэмж сайжирсан бөгөөд Тохижилтийн ажлын гэрээг 1608 аж ахуйн нэгж байгууллагуудтай хийж, хяналт тавин ажиллаж байна.	70.0
169.	Орон сууцны хороолол, гэр хороолол, нийтийн эзэмшлийн гудамж, талбайн гэрэлтүүлэг, чимэглэлийн талаар мэдээллийн санг бүрдүүлэн, судалгааг	ДБТХ	Дүүргийн нутаг дэвсгэрийн орон сууц, гэр хороолол, нийтийн эзэмшлийн зам талбайн гэрэлтүүлгийн тооллого явуулж Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Дүүргийн нутаг дэвсгэрийн нийтийн эзэмшлийн зам талбайд 2061 ш, орон сууцны хорооллын дунд 534 ш, гэр хорооллын гудамжинд 3440	100.0

		баяжуулах, мэргэжлийн байгууллагын зөвлөгөөгөөр хангах		ширхэг, нийт 6035 ширхэг гэрэлтүүлэг байна. 2013 оны 6-р сарын 1-ний өдрөөс нутаг дэвсгэрийг “А”, “Б” бүс болгон хувааж “Филипс” ХХК,” БИ ЭМ ЖИ ЭЛ” ХХК гэсэн мэргэжлийн 2 байгууллага ашиглалтыг хариуцан ажиллаж байна.	
170.		Гудамж, талбайд байрлуулсан байгууллага, аж ахуйн нэгжийн реклам, зар сурталчилгааны самбар, байгууламжид тавих хяналтыг сайжруулж, стандартын шаардлагыг мөрдүүлж ажиллах	ДБТХ	Дүүргийн Засаг даргын 2013 оны 48 дугаар захирамжаар Москвагийн гудамжны цагаан зурвасд байрлуулсан 104 байгууламжийг, 2013 оны 11-р сарын 445 дугаар захирамжаар дүүргийн нутаг дэвсгэрт байрлалтай стандарт бус, зөвшөөрөлгүй 48 байгууламжийг тус тус албадан буулгах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын зардалд нийслэлийн төсвөөс 38 сая, дүүргийн төсвөөс 13.6 сая төгрөгийг гарган зарцуулсан. Дүүргийн Засаг даргын 2013 оны 264 дугаар захирамжаар урьд байгуулсан гэрээгээ зөрчилгүй биелүүлж ажилласан 20 ААНБ-ын зар сурталчилгааны болон мэдээллийн байгууламжийн гэрээг сунган 2013 онд дүүргийн төсөвт 102.3 сая төгрөгийн хураамжийг төвлөрүүлсэн болно.	100.0
171.	3.2.4	Мэргэжлийн байгууллагын хүн, хүчийг нэмэгдүүлж гол автозам болон орон сууцны хорооллын автозамуудыг арчилгаа, цэвэрлэгээнд бүрэн хамруулах	ДБТХ	Нийтийн эзэмшлийн авто замын цэвэрлэгээг 2 ээлжээр цэвэрлэх хуваарь гарган нийт 18 гудамж талбайг 51 үйлчлэгч өглөө 06.00 цагаас орой 21.00 цаг хүртэл цэвэрлэж байна.	90.0
172.	3.2.5	Дүүрэгт шинээр баригдаж байгаа болон засварлаж байгаа зам, барилгын ажил, Албан байгууллага, нийтийн үйлчилгээний барилга байгууламж, нийтийн эзэмшлийн зам, талбайд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчинг бүрдүүлэх стандартыг мөрдүүлэх	ДБТХ	Авто замын ажлын хүрээнд Нийслэлийн Авто замын сангийн хөрөнгөөр хийгдэж буй бүтээн байгуулалт, тохижилтын ажлаар Саппорогоос Таван шарын автобусны буудал хүртэл, Ханын материалын уулзвараас Баянхошууны тойрог хүртэл, Зүүн салааны явган хүний зам тохижуулж, тусгай зурваст хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан зам тавьсан.	90.0
173.	3.2.6	Байршлыг тогтоон газрын асуудлыг шийдвэрлэх	ӨГХА, ДБТХ	Дүүргийн ИТХ-ын 2013 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 5/2 дугаар тогтоолоор 20, 32-р хорооны нутаг дэвсгэр Сонгинохайрхан уулын бэл, голын тохой орчмын 650.5 га газрыг Орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан ба тодорхой хэсэгт нь дүүргийн цэцэрлэгт хүрээлэн байгуулахаар тусгагдсан болно.	100.0
174.	3.2.7	Иргэдийн санал хүсэлтийг судлан, байршлыг тогтоох	ДБТХ	Дүүргийн орон сууцны хорооллын 12 хорооны нутаг дэвсгэрт өндөр багтаамжтай авто зогсоол, граж шинээр байгуулах	70.0

				байршлын саналыг хороодоос авч Засаг даргын Тамгын газрын 3/1872 тоот албан бичгээр нийслэлийн Эдийн засгийн хөгжлийн газарт хүргүүлсэн.	
<b>Дөрөв. Экологи, байгаль орчныг хамгаалахад ахиц дэвшил гаргана.</b>					
175.	4.1	Эрчим хүчний хэмнэлттэй, ердийн халаалтын зуухыг гэр хорооллын 8000 өрхөд нийлүүлэх	ДБТХ	“Бүрэн шаталттай зуухны төсөл”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Rayol ocean” маркийн “Дөл” зуух 3519, “Өлзий” зуух 1586, “Векас-107” маркийн зуух 277, “Талст” зуух 4 нийт 5383 айл өрхөд ердийн халаалтын зуух борлуулагдсан. Цахилгаан халаагуур хэрэглэсэн 114 өрх, ердийн халаалтын зуух авсан 2108 өрх цахилгааны хөнгөлөлтөнд хамрагдаад байна.	90.0
176.		Байгууллага, иргэд өөрийн хөрөнгөөр утааны шүүлтүүр болон утаа бууруулах зориулалттай тоног төхөөрөмж суурилуулсан тохиолдолд Цэвэр агаарын сангаас зардлыг нөхөж өгөх ажлыг зохион байгуулах	ДБТХ	Байгууллага, иргэдээс өөрийн хөрөнгөөр утааны шүүлтүүр болон утаа бууруулах зориулалттай тоног төхөөрөмж суурилуулах хүсэлт ирээгүй байна.	-
177.		Агаарын бохирдлыг бууруулах хязгаарлалтын бүсийн 300-аас доошгүй айл, өрхийг утаа шүүгчээр хангах	ДБТХ	Нийслэлийн Баянгол дүүргийн айл өрхөд туршилтын журмаар утаа шүүгч суурилуулсан боловч шаардлага хангахгүй байсан тул цаашид бусад дүүрэгт хэрэгжүүлэх шаардлагагүй гэж үзсэн байна.	-
178.		Агаарын бохирдлыг бууруулах бүсчлэлд хамрагдсан хороодын усан халаалтын зуухтай өрхүүдэд Канадын зуухыг нэвтрүүлэх	ДБТХ	“Хүрд ” ХХК-ны Канад технологийн усан халаалтын зуухыг 2013 оны 01 дүгээр сарын 17-ны өдрөөс эхэлсэн бөгөөд нийт 2106 айл өрхөд суурилуулах ажлыг хийгээд байна.	90.0
179.	4.2	Нутаг дэвсгэрийн ойн сан бүхий тодорхой талбайг нөхөн сэргээх, ойн арчилгаа цэвэрлэгээ хийх	ДБТХ	Дүүргийн нутаг дэвсгэр Хүй долоон худаг орчимд ойн зурвас байгуулах гүйцэтгэгчээр “Цэцэрлэгжилт” ХХК, 21 дүгээр хорооны Төмөр замын 361 гарам орчим ойн зурвас байгуулах гүйцэтгэгчээр “Ногоон харш” ХХК-иуд шалгаран ажиллаж байна. 32-р хорооны нутаг дэвсгэр 22-ын товчооноос 361-ын гарам, Хүй долоон худаг хүртэлх автозамын 2 талаар ойн зурвас байгуулах санаачлага гарган “Ойн судалгаа хөгжлийн төв”-ийн Ногоон хэрэм үндэсний хөтөлбөрт Дэд бүтэц, тохижилтын хэлтсийн даргын 3/1613 тоот албан бичгээр саналаа хүргүүлж, нийт 9.0 сая төгрөгийг дүүргийн Засаг даргын Тамгын газрын дансанд шилжүүлж ажил эхлэхэд бэлэн болсон. 2013 оны хавар	50.0

				намрын “Мод тарих үндэсний өдрөөр” дүүргийн байгууллага, аж ахуй нэгжүүд. иргэд нийт 15765 ширхэг мод бут, сөөг тарьсан.	
180.	4.3	Ногоон бүсийн хортоншавьж, өвчнийтархалтынсудалгаанд үндэслэнхортон шавьж өвчний устгалыг хийх	ДБТХ	Дүүргийн ногоон бүсэд ойн хортон шавьжийн устгал хийгдэх ажил Байгаль Орчин Ногоон Хөгжлийн Яам, Нийслэлийн Байгаль Орчин Ногоон Хөгжлийн газрын судалгааны дүнд тулгуурлан мэргэжлийн байгууллага хийж гүйцэтгэхээр болсон.	-
181.	4.4	Ногоон бүсийн тодорхой хэсгийг хамгаалахаар иргэдээс ирүүлсэн санал, санаачлагыг судлан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд асуудал оруулах, хамтран ажиллах	ДБТХ	Толгойтын Баруун, Зүүн салааны ойн сан бүхий газрыг хамгаалалтанд авч нөхөрлөл байгуулах саналыг иргэн Доржсүрэн, Д.Лхагвасүрэн, Баатар, Жамба нар гаргасан. Энэ талаар шийдвэр гаргах асуудлыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барихаар бэлтгэж байна.	50.0
182.	4.5	8-р хорооны Гүнжийн нуур орчмыг сэргээн засварлах, 22-р хорооны Бөөрийн булгийн орчныг тохижуулж хамгаалалтанд авах	ДБТХ, ӨГХА	22-р хороо Тахилтын амны Бөөрийн /7.0 сая/ болон 7-р хорооны Чандмань /20 сая/ булгийг Орон нутгийн хөгжлийн сангийн төгрөгөөр тохижуулахаар зураг төслийг боловсруулан гүйцэтгэчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан. 8-р хорооны Гүнжийн нуур орчимд бичил цэцэрлэг байгуулах ажлыг Нийслэлийн Байгаль орчин ногоон хөгжлийн газраас нийт 2,2 га-д 461.2 сая төгрөгийн төсөвт ажил эхэлсэн боловч улирлын чанартай зогссон.	50.0
183.	4.6	Нөхөн сэргээлтийн ажлыг үргэлжлүүлэн хийж мэргэжлийн байгууллагатай хамтран хяналт тавьж ажиллах	ДБТХ, МХХ	Дүүргийн 20,32 дугаар хорооны нутаг дэвсгэр Туул голын савд 11 аж ахуйн нэгж байгууллага 2001-2009 оны хооронд түгээмэл тархацтай ашигт малтмал олборлож, байгаль орчны талаарх хуулиар хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлж, голын ай савыг их хэмжээний доройтолд оруулсан тул ашиглалтын тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгосон. Нийслэлийн Байгаль хамгаалах газартай байгуулсан гэрээний үндсэн дээр ашиглалтын тусгай зөвшөөрөл нь цуцлагдсан аж ахуйн нэгжийн хайрганы ордын ашиглалтын үйл ажиллагааны улмаас байгаль орчинд учруулсан хохирол, нөхөн төлбөр тооцох зардлын хэмжээг тогтоох ажлыг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх эрх бүхий мэргэжлийн байгууллагын баг хийж гүйцэтгэн, 8,8 тэрбум төгрөгийн хохирол учруулсаныг тогтоосон.Ашиглалтын тусгай зөвшөөрөл цуцлагдсан аж ахуйн нэгж байгууллагуудын техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн байдалд хяналт шалгалтыг хийж, илэрсэн зөрчлийг арилгах, нөхөн сэргээлтийн ажлыг	90.0

				эрчимжүүлэх зорилгоор албан шаардлагыг хүргүүлэн гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу төлөвлөгөө гаргаж ажлаа бүрэн хийж дуусган хүлээлгэж өгөхийг мэдэгдсэн. Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 “к”, “Газрын тухай” хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь заалт, “Тусгай хамгаалалтай газар нутгийн тухай” хуулийн 3 дугаар зүйлийн 3.2, 28 дугаар зүйлийн 28.3, 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтуудыг удирдлага болгон дүүргийн нутаг дэвсгэрийн “Сонгинохайрхан” уулын зүүн бэл, голын тохой орчимын 683 га газар, 21 дүгээр хорооны Бурхантын амны 484 га газрыг орон нутгийн тусгай хамгаалатанд авч, байгалийн унаган төрхийг нь хадгалж, цэцэрлэгт хүрээлэн, амралт, аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор газрын хэмжээ, хилийн цэс, “Дүүргийн тусгай хамгаалалтанд авсан газарт хэрэгжүүлэх үйл ажиллагааны горим”-ыг тус тус баталсан. Нийслэлийн Байгаль Орчин Ногоон Хөгжлийн газар дээрхи нэр бүхий 13 компантай нөхөн сэргээх талаар хугацаатай гэрээ байгуулан ажиллаж байна.	
184.	4.7	Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд айл өрх болон аж ахуйн нэгжүүдийн ашиглаж байгаа гүний худгийн тооллого зохион байгуулах	СХ, ЗХХ	Дүүргийн Засаг даргын 2013 оны 321 дүгээр захирамжаар, дүүргийн нутаг дэвсгэрт гүний худгийн тооллого зохион байгуулан явуулах ажлын хэсгийг Засаг даргын дэд бүтэц, нийтийн аж ахуйн асуудал хариуцсан орлогчоор ахлуун байгуулсан. Дүүргийн хэмжээнд гүний худгийн тооллого явуулах удирдамж, төлөвлөгөөг дүүргийн Засаг даргаар батлуулан ажилласан бөгөөд нийт 6 тоологч ажилласан. 8 дугаар сарын 15-наас гүний худгийн тооллого эхэлж 9 дүгээр сарын 15-нд дуусгасан бөгөөд дүүргийн хэмжээнд 950 худаг тоологдсон бөгөөд үүнээс 332 буюу 35 орчим хувь нь аж ахуйн нэгж, байгууллагын, 603 иргэний худаг тоологдсон бөгөөд 15 худгийн эзэмшигчийг тогтоож чадаагүй байна. Гүний худгийн тооллого явуулахад нийт 1.4 сая төгрөгийн зардал гарсан болно.	100.0
185.		Иргэдийн ундны усны хэрэгцээнд ашиглаж байгаа булаг, шанд гүний худгийн усыг шинжилгээнд хамруулах	ДБТХ, МХХ	Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй 10 аж ахуйн нэгж байгууллага, 6 иргэний гүний худаг, 24 дүгээр хороонд байрлах Бумбатын рашаан тус бүрээс ундны усны болон гадаргын усны дээж авч НМХГ-ын төв лабораторид шинжлүүлэхэд стандартын шаардлага хангасан үзүүлэлттэй гарсан байна.	90.0

186.		Гэр хорооллын хороодын бохирын цооног, 00-ыг ариутгах ажлыг хийх	ДБТХ, МХХ	Гэр хорооллын Засаг дарга нар Хунтхайрхан, Ариун хос вансэмбэрүү, Бат ариусгал ХХК-уудтай гэрээ байгуулан давхардсан тоогоор 17.6 мянган жорлон, бохирын цооногийн ариутгалыг гүйцэтгүүлсэн болно.	70.0
187.	4.8	Тээвэрлэлт үйлчилгээний төвийн гражийн барилгын санхүүжилтийг орон нутгийн хөгжлийн сангаас шийдвэрлэн гүйцэтгэж, ашиглалтанд авах	ДБТХ, ТҮТ	Сангийн сайдын 2013 оны 244 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу Тээвэрлэлт үйлчилгээний төвийн гражийн барилгын хөрөнгийг Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр шийдэх боломжгүй тул асуудлыг Нийслэлийн 2014 оны төсөвт тусгуулахаар саналаа хүргүүлсэн.	-
188.		Хог тээврийн болон авто зам цэвэрлэгээний тусгай зориулалтын техник, хэрэгслийн хүчин чадлыг нэмэгдүүлэх	ДБТХ	Хог хаягдлыг тээвэрлэгч байгууллагуудын хүчин чадлыг нэмэгдүүлэн хог тээврийн зориулалтын Солонгос улсад үйлдвэрлэсэн задгай тэвштэй 15 тн-ийн даацтай Daewoo маркийн автомашин 5, Hyundai маркийн тусгай зориулалтын 5 тн-ын даацтай автомашин 2 ширхгийг тус тус Нийслэлийн хөрөнгө оруулалтаар авсан. Хог тээврийн болон авто зам цэвэрлэгээний тусгай зориулалтын техник, хэрэгслийн хүчин чадлыг нэмэгдүүлэх саналын жагсаалтыг гарган Нийслэлийн Захирагчийн ажлын албаны Тохижилт, Хог Хаягдлын Удирдлагын хэлтэст хүргүүлсэн.	90.0
189.		Гэр хорооллын айл өрхийн хогийг сард 2 удаа хашаанаас нь авах ажлыг хэвшүүлэх	ТҮТ	Хог тээврийн 3 байгууллагад задгай тэвштэй 38 авто машинаар 22 гэр хорооллын хогийг сард 1,7 удаагийн давтамжтайгаар хашаанаас нь авахуулж хэвшсэн. “Өрх бүрт ногоон уут, ам бүрт эко үйлчлэгч” ажлын хүрээнд 1.4 сая гаруй хогны уутыг 10-р сараас эхлэн айл өрхүүдэд тараасан байна.	70.0
<b>Тав. Нутгийн захиргааны байгууллагын ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, үйлчилгээг ил тод, хөнгөн шуурхай болгоно.</b>					
190.	5.1	Дүүрэг, хороодод суурин болон явуулын иргэний танхим байгуулан, тулгамдсан асуудлаар иргэдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулан ажиллах	ЗХХ	Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 09 дүгээр тогтоолоор “Иргэний танхим”-ыг 3 ажилтантай байгуулан төсөв, ажиллах журмыг батлан, Засаг даргын Тамгын газрын байранд 84 хүний суудалтай иж бүрэн тоног төхөөрөмж бүхий Иргэний танхимыг байгуулан ажиллуулж байна. 7, 8, 10, 16, 18, 19, 21, 22, 23, 25, 29, 31-р хороодод иргэний танхимыг байгуулан үйл ажиллагаа нь жигдэрч байна. Хороодын иргэний танхимаар 2013 оны “Орон нутгийн хөгжлийн сан”-гийн хөрөнгөөр хийх ажлын хэлэлцүүлэг, “Манай хороо-миний оролцоо” сэдэвт иргэдийн хэлэлцүүлэг, нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа эрхэлж байгаа “Тоосгоны үйлдвэрийг нутаг дэвсгэрээс гаргах” хэлэлцүүлэг,	100.0

				“Иргэний оролцоотой төсөв-2014” хэлэлцүүлгийг зохион байгуулав.	
191.		Нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд иргэд, үйлчлүүлэгчдийн үнэлгээг тогтмол хийлгэж хэвших	ЗХХ	Дүүргийн вэб сайтаар дамжуулан төрийн байгууллагын үйлчилгээний талаар асуулга авснаас 47.5% маш хангалттай, 12.6% хангалттай, 11.2% дунд зэрэг, 2,3% хангалтгүй, 26.4% маш хангалтгүй гэсэн үнэлгээг өгчээ. Дүүргийн нэг цэгийн үйлчилгээгээр үйлчлүүлсэн 498 хүнээс сэтгэл ханамжийн судалгаа авсан. Тус төвөөр өдөрт 900-1000 хүн үйлчлүүлдэг ачаалал ихтэй тул дугаарлалтыг багасгах талаар иргэдээс санал гомдол их ирдэг. Тиймээс эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үйлчилгээ үзүүлж байгаа ажилтны тоог нэгээр нэмсэн. Мөн төлбөр хураамжийг төвлөрүүлдэг ХААН банкны теллерийн тоог нэмэгдүүлэх албан бичиг ХААН банкны удирдлагуудад илгээсэн ч нэмэгдүүлэх боломжгүй гэдгийг мэдэгдсэн. Үйлчлүүлж болон үйлчилж байгаа ажилтнуудын ажиллах ая тухтай орчин бүрдүүлэхийн тулд хаяг жигдрүүлэх, тохижилтын ажлыг тухай бүрт нь хийсэн. Мөн ТҮЦ машин, хөдөлмөрийн цахим машин зэргийг байршуулснаар иргэд төрийн үйлчилгээг нэг дороос цахим хэлбэрээр авах боломжийг бүрдүүлсэн.	90.0
192.		Хороодоос иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг нэг цонхны хэлбэрт шилжүүлэх ажлыг үргэлжлүүлэх	ЗХХ	Нийт 32 хорооноос 21 хороог нэг цонхны үйлчилгээнд шилжүүлсэн байна.	70.0
193.		10.0 мянгаас дээш хүн амтай 1, 2, 3, 7, 22, 23, 25, 26, 31-р хороодын ажлын ачааллыг тэнцвэржүүлж, хилийн заагийг шинэчлэх асуудлыг боловсруулан холбогдох байгууллагуудад хүргэх	ЗХХ	1, 2, 3, 7, 22, 23, 25, 26, 31 хороодын хүн амын тоо, газар нутгийн онцлог, байршлыг харгалзан хороог хуваах саналыг хороодоос урьдчилсан байдлаар авсан. Дээрх ажил нь судалгааны түвшинд явж байна.	30.0
194.		Хороодын хүн ам, өрхийн 2012 оны жилийн эцсийн статистик тоог үндэслэн хэсгийн ахлагчийн тоог шинэчлэн тогтоох	ЗХХ	2012 оны жилийн эцсийн байдлаар дүүргийн нийт хүн ам 261917, өрхийн тоо 65423 байна. Оны эхэнд 32 хороонд нийт 226 хэсгийн ахлагч ажиллаж байгаа бөгөөд судалгаагаар гэр хороололд 14, байшин хороололд 2, нийт 16 хэсгийн ахлагч нэмж ажиллуулах шаардлагатай гэсэн дүн гарсан. 7 дугаар хороонд шинээр 3, 18 дугаар хороонд шинээр 2, 24 дүгээр хороонд шинээр 2, 29 дүгээр хороонд шинээр 2, хэсгийн ахлагч нийт 9 хэсгийн ахлагчтай хөлсөөр ажиллах гэрээ байгуулан ажиллуулж байна.	100.0

195.		Нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах	ЗХХ	Нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг сурталчлах зорилгоор Монголын үндэсний олон нийтийн телевиз, MN25, ETV, MNC, TV5, PPTV, “Монгол HD”, UBS, “Эх орон”, “Шинэ дэлхий” зэрэг телевизүүдтэй хамтран ажиллаж байна. 2013 оны байдлаар эдгээр болон бусад кабелийн телевизүүдээр нийт 26 мэдээ, мэдээлэл, “Өдрийн сонин”, “Улаанбаатар пост”, “Өнөөдөр” зэрэг өдөр тутмын сонинд 25 мэдээ тус тус хэвлэн нийтлүүлсэн. Дүүргийн <a href="http://www.shd.mn">www.shd.mn</a> сайтад нийт 357 мэдээ, мэдээлэл, тавьсанаас дүүргийн Засаг даргын захирамж 63, тендерийн зар 55, дүүргийн 2013 оны аудитлагдсан төсөв, ажлын байрны тодорхойлолт, сул ажлын байрны захиалга, <a href="http://www.ulaanbaatar.mn">www.ulaanbaatar.mn</a> , болон бусад сайтад нийт 39 мэдээ мэдээлэл нийтлүүлж сурталчилсан.	100.0
196.	5.2	Хүн амын механик өсөлттэй холбогдон нутгийн захиргааны байгууллагаас иргэдэд үзүүлэх үйлчилгээнд гарч буй хүндрэл, нөхцөл байдлыг судлан тооцоо судалгаа хийх	ЗХХ	Дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 10-р сарын 29-ний А/163 дугаар тогтоолоор дүүргийг хуваан шинээр дүүрэг байгуулах асуудлыг судлан, санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дүүргийн Засаг даргын эдийн засаг, санхүү, төлөвлөлтийн асуудал хариуцсан орлогчоор ахлуулан 11 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан байна. Дүүрэг хуваан шинээр дүүрэг хуваах асуудлыг дэмжих эсэх асуудлаар 32 хорооны 31.4 мянга орчим иргэдийн дунд /өрхийн 48.1%, нийт хүн амын 12.0%, 18-аас дээш насны хүн амын 17.9 хувийг хамруулан/ асуулга зохион байгуулахад 74.8 % нь тийм, 25.2% нь үгүй гэсэн санал өгсөн байна. Ажлын хэсэг дүүргийг хуваах 2 хувилбар гарган газрын зураг хийлгэж байна.	90.0
197.	5.3	Төрийн үйлчилгээний зарим, боломжит хэсгийг цахим хэлбэрт шилжүүлэх	ЗХХ	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын <a href="http://www.shd.mn">www.shd.mn</a> вэб сайтны “Нээлттэй” цэс дотор “Хуулийн зөвлөгөө” дэд цэс үүсгэн иргэдэд цахимаар хууль, эрх зүйн зөвлөгөөг өгч байна. “Таны хөтөч” цэс үүсгэж төрийн үйлчилгээг авахад шаардлагатай бүрдүүлэх материалын жагсаалтыг байршуулсан. <a href="http://www.smartcity.mn">www.smartcity.mn</a> сайтаар иргэдийн санал гомдлыг цахимаар хүлээн авч, шийдвэрлэлтэд хяналт тавин ажиллаж байна. Төрийн үйлчилгээний ТҮЦ машиныг ЗДТГ-ын Нэг цонхны үйлчилгээний төв болон 11, 16, 20 дугаар хороодод тус тус байршуулсан. Е бирж хөдөлмөрийн цахим машиныг ЗДТГ-ын байранд 2, хороодод 27, дүүргийн Татвар, Хөдөлмөрийн хэлтэст тус тус нэгийг байршуулсан. Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивын 57459 хувийн хэргээс 60 хувь буюу	90.0



			34500 хувийн хэргийг цахимжуулаад байна.	
198.	Веб сайтын шинэчлэлт хийн, төсөв, хүний нөөц, худалдан авах ажиллагааны тухай мэдээлэл, захирамжлалын баримт бичгийг цахим хуудсанд тогтмол, шуурхай байршуулах	ЗХХ	Вэб сайтын шинэчлэлтийг хийхээр “Supersolution” ХХК-тай 2013 оны 2 дугаар сарын 1-ээс эхлэн 1 жилийн хугацаатай хамтарч ажиллах гэрээ байгуулсан. Тус сайтад нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 357 мэдээ, мэдээлэл, шуурхай зөвлөгөөний дүүргийн болон нийслэлийн ерөнхий менежерийн үүрэг даалгавар, үүрэг даалгаврын биелэлт нийт 34 бусад мэдээ мэдээллийг цаг тухай бүр нь шуурхай цахим хуудсанд оруулж байна. <a href="http://www.shd.mn">www.shd.mn</a> вэб сайтны бүтэц болон загварыг шинэчлэн гарган, бүтцийг статик, динамикаар нь ангилан сайжруулсан. Мөн <a href="http://www.facebook.com">www.facebook.com</a> , <a href="http://www.zasag.mn">www.zasag.mn</a> вэб сайтууд дээр тус дүүргийн холбогдолтой мэдээллийг цаг тухайд нь оруулж байна. <a href="http://www.shd.mn">www.shd.mn</a> вэб сайтад “Тендерийн зар”, “Тендерийн явц”, “Тендерийн үр дүн” цэс үүсгэж мэдээ мэдээлэл оруулж байна. Мөн <a href="http://www.shd.mn">www.shd.mn</a> сайтад Нээлттэй ->Таны хөтөч цэс үүсгэж төрийн үйлчилгээг авахад шаардлагатай бүрдүүлэх материал, хүний нөөцийн тухай мэдээлэл байршуулсан.	100.0
199.	Хороодод иргэний гэр бүлийн байдлын зарим бүртгэлийг хийх ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх	БХ	Иргэдийн шилжилт хөдөлгөөнийг хороодод бүрэн хийж байгаа ба 10-р сараас үрэгдүүлсэн төрсний болон гэрлэлтийн гэрчилгээг олгож эхэлсэн.	100.0
200.	Хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтрийн хөтлөлтийг сайжруулж, хүн амын мэдээллийн санг бүрдүүлэх	СХ	Хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтрийн хөтлөлтийг сайжруулах, хүн амын мэдээллийн санг бүрдүүлэх ажлын хүрээнд 4-р сард нийслэлийн Статистикийн газартай хамтран хороодын Засаг дарга, зохион байгуулагчдын сургалтыг зохион байгуулсан. 11-р сарын 10-ны байдлаар 65423 өрхийн 261917 хүний мэдээлэл Хүн амын мэдээллийн санд орохоос 58997 өрх буюу 223877 хүний мэдээлэл мэдээллийн санд шивсэн байдалтай байна. Дүүргийн хэмжээнд 85,5 хувьтай байна. Хороодод мэдээллийн сангийн бүрдүүлэлтийн явцад 2 удаа хяналт шалгалт хийн зөвлөгөө өгч ажиллав. Нийт 8 хороо мэдээллийн санг бүрэн бүрдүүлсэн, 8 хороо 90-ээс дээш, 7 хороо 80-90%, үлдсэн хороод 37.6-78.5 хувийн гүйцэтгэлтэй байна.	90.0
201.	9 хороог өндөр хурдны шилэн кабельд холбох	ЗХХ	Нийслэлийн мэдээлэл технологийн газартай гэрээгээр хамтран ажилладаг “Lead link” ХХК тус дүүргийн шилэн кабелийн засвар үйлчилгээг хариуцан ажилладаг.Нийт 32 хорооноос 4, 6, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 20, 27, 30, 31 дүгээр хороод дүүргийн ЗДТГ-	-

				ын байрнаас шилэн кабель татаж дотоод болон гадаад сүлжээнд холбогдож байна. Мөн 1, 2, 3, 5, 7, 8, 9, 10, 11, 22, 25, 28 дугаар хороо нь шилэн кабельд холбогдсон боловч зам засварын ажлаас шалтгаалан тасарсан. 21, 23, 24, 26, 29, 32 дугаар хороодыг шилэн кабельд холбох хөрөнгө нийслэлийн Мэдээлэл, технологийн газрын 2013 оны төсөвт суугаагүйн улмаас интернэтэд холбогдоогүй байна. Шилэн кабельд холбогдоогүй хороодыг үүрэн холбооны Скайтел, Жи мобайлийн модемоор хангаж, хэвийн үйл ажиллагаа явуулж байна. Газар нутгийн байршлаас хамааран 1, 22 дугаар хороог “Улуснэт” ХХК-ийн тасалгааны төхөөрөмжөөр интернэтэд холбосон.	
202.		Дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг шаардлагатай үед цахим хэлбэрээр хийх боломжийг судлан шийдвэрлэх	ЗХХ	Дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг цахимаар явуулах зорилгоор “I Wow We” ХХК-ийн нэвтрүүлж буй программыг судлан, туршилтын онлайн хурал 1 удаа зохион байгуулсан. Онлайн хурал зохион байгуулах программыг худалдан авах хөрөнгийг ЗДТГ-ын 2014 оны төсөвт суулгуулах саналыг өгсөн.	70.0
203.	5.4	Газрын асуудлыг судлах	ЗХХ, ӨГХА	Дүүргийн 27-р хороо Засаг даргын Тамгын газрын урд байрлах Цагдаагийн эрүүлжүүлэх байрыг буулгаж тус байршилд Нутгийн захиргааны ордон барих санал боловсруулаад байна.	100.0
204.	5.5	1, 2, 3, 4, 9, 10, 11-р хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн цогцолбор байрны барилгын гүйцэтгэчийг сонгон шалгаруулж, ажлыг эхлүүлэх	ЗХХ	Нийслэлийн Засаг даргын 2013 А/340 захирамжаар үнэлгээний хороо байгуулан 1, 2, 3, 4, 9, 10, 11-р хороонд иргэдэд нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилгын ажил гүйцэтгэчийг сонгон шалгаруулсан.10-р хорооны цогцолбор барилга барихаар төлөвлөсөн газрын хэмжээ бага байсан тул дүүргийн Засаг даргын 342 дугаар захирамжаар тус хорооны 17 дугаар гудамжинд барилга барихаар төлөвлөсөн. Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газраас гудамжны дунд гэсэн шалтгаанаар барилга барих ажлыг зөвшөөрөөгүй бөгөөд газрыг дахин судлаж үзэх шаардлагатай. 1,4 дүгээр хороодын цогцолбор байрны барилгын ажил дууссан, дотор засвар болон гадна тохижилтын ажил хийгдэж байгаа. 2,11 хороодын цогцолбор байрны 1 давхарын хэсэг дууссан. Барилгын ажлын гүйцэтгэл 30 хувьтай байна. 3-р хорооны цогцолбор барилгын суурийн цутгалт хийгдсэн.	90.0
205.		12, 23, 25, 26, 28-р хороодын	ЗХХ	22, 26-р хороодын гадна тайлбайн тохижуулах ажил бүрэн дуусаж	90.0

		цогцолбор байрны гадна талбайг тохижуулах, засвар хийх		12, 17, 19, 20, 23, 25, 28-р хороодын байрны засвар, гадна тохижилтыг орон нутгийн сангийн хөрөнгөөр хийхээр компанитай гэрээ байгуулан ажлаа эхлүүлээд явж байна.	
206.	5.6	Албан хаагчдыг мэргэшүүлэх, урт, богино хугацааны гадаад, дотоодын сургалтанд хамруулах	ЗХХ	Гадаадын богино хугацааны сургалтанд 5, мэргэшүүлэх сургалтанд 6, салбарын /харъяа дээд байгууллага/ сургалтанд давхардсан тоогоор 420 төрийн албан хаагчдыг мэргэжлийн дагуу сургалтанд тус тус хамруулсан. Ажлын байран дээрхи сургалтыг /Мэдээллийн цаг/ тусгай төлөвлөгөөний дагуу Тамгын газрын албан хаагчдад 8 удаа, хороодын Засаг дарга нарт 10, зохион байгуулагчдад 12, нийгмийн ажилтнуудад 15, хэсгийн ахлагч нарт 2 удаа тус тус зохион байгуулсан.	90.0
207.		Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлага алдсан болон ашиг сонирхлын зөрчилтэй албан хаагчдад тооцох хариуцлагыг нэмэгдүүлэх, зөрчлийг арилгуулах ажил зохион байгуулах	ЗХХ	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчидтай холбоотой төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлага алдсан, ашиг сонирхлын зөрчилтэй гэх 13 гомдлыг /Авлигатай тэмцэх газарт-1, Нийслэлийн Засаг даргын тамгын газарт-1, Дүүргийн Засаг даргын тамгын газарт -11 / иргэдээс гаргасан байна. Үүнээс 2 иргэн гомдлоосоо татгалзаж өөрийн хүсэлтээр өргөдлөө буцаасан. 11 иргэний гомдолд хариу тайлбарыг хугацаанд нь өгч шийдвэрлэв. Ажлын сахилга, хариуцлага алдсан 10 төрийн албан хаагчдад сахилгын шийтгэл ногдуулав. Дүүргийн "Ёс зүйн зөвлөл" байгуулсан. УИХ-ын гишүүн, Авлигатай тэмцэх газар, Нутгийн удирдлагын холбоо, Азийн хөгжлийн сан, Хуульч эмэгтэйчүүдийн холбоо, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албатай хамтран 8 удаагийн сургалт, зөвөлгөөн, хэлэлцүүлгийг дүүргийн Засаг даргын дэргэдэх харьяа, хэлтэс албадын удирдах албан тушаалтнууд, тамгын газрын төрийн албан хаагчид, иргэдийн дунд тус тус зохион байгуулсан.	100.0
208.		Төрийн албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх дүүргийн дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх	ЗХХ	Дүүргийн Засаг даргын 2013 оны 386 дугаар захирамжаар дэд хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийг Засаг даргын нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогчоор ахлан байгуулан "Төрийн албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх дэд хөтөлбөр"-ийг боловсруулсан бөгөөд Засаг даргын зөвлөлийн хурлаар 12-р сард хэлэлцүүлэн батлуулна. Төрийн албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор 64 албан хаагчийг хямд үнэтэй орон сууцаар хангах, 146 албан хаагчийг түлээ, нүүрсний	70.0

				хөнгөлөлт хамруулах, 28 хүнд 158.0 сая төгрөгийн буцалтгүй тусламж олгох зэрэг ажлыг зохион байгууллаа.	
209.	5.7	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор нийтийн эзэмшлийн гудамж талбай, гэр хорооллыг телекамерын системд хамруулах	ЗХХ, ЦХ I, II	Иргэдийн аюулгүй байдал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, үйлдэгдсэн гэмт хэргийг цаг алдалгүй илрүүлэх, гарсан осол зөрчлийн бодит үнэнийг тогтоох, хөдөлгөөнд оролцогчдын сахилга соёлыг дээшлүүлэх үүднээс хүн амын нягтаршил болон дэд бүтцэд тулгуурлан бүрэн хяналтын системийг суурилуулах шаардлагатай байгаа талаар Хууль зүйн Яам, НЗДТГ, Нийслэлийн Өмчийн Харилцааны газарт албан бичиг явуулсан. Өмчийн харилцааны газраас 6/1757 тоотор Нийслэлийн санхүү төрийн сангийн хэлтэст хандаж шийдвэрлүүлэх талаар хариу ирсэн.НЗДТГ хөрөнгийн эх үүсвэрийг энэ ондоо багтаан шийдвэрлэх боломжгүй талаар мэдэгдсэн.	-
210.		Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор иргэд, олон нийтийн байцаагч, эрх зүйн хөтөч нарын дунд төсөл шалгаруулж, нийслэлийн ГХУССЗөвлөлд уламжлах	ЗХХ, ЦХ I, II	Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны А/141 дүгээр тогтоолоор “Гэмт хэрэг зөрчилгүй жишиг хэсэг” болзолт уралдааныг 2013 оны 09 дүгээр сарын 20-ний өдрөөс 11 дүгээр сарын 20-ний өдрийг хүртэл 2 сарын хугацаатай зарлалаа. Болзолт уралдааны шалгуур үзүүлэлтэнд иргэдийн дунд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар хийж хэрэгжүүлэх ажлын төсөл боловсруулан ирүүлэх заалт оруулж, нийт 5 төслийг Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд хүргүүлэхээр шийдвэрлэсэн. Болзолт уралдааны шагналын сан 7,5 сая төгрөг болно.	90.0
211.		Цагдаагийн байгууллагын техник, хэрэгслийн хангамжийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх	ЗХХ	Цагдаагийн байгууллагын техник, хэрэгслийн хангамжийг сайжруулах зорилгоор орон нутгийн хөгжлийн сангаас 25.0 сая төгрөгийн компьютер, техник тоног төхөөрөмж худалдан авахад дэмжлэг үзүүлэв.	100.0
212.	5.8	“Архигүй баасан гараг” дүүргийн дэд хөтөлбөр боловсруулж батлуулан хэрэгжүүлэх	ЗХХ	Дүүргийн Засаг даргын 2013 оны 311 дүгээр захирамжаар дэд хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг 3 удаа хуралдан сүүлийн 2 жилийн хугацаанд Баасан гарагт үйлдэгдсэн гэмт хэргийн харьцуулсан судалгаанд дүн шинжилгээ хийн дэд хөтөлбөр /2014-2016 он/, 5 бүлэг, 31 заалт бүхийхөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулав.	70.0
213.	5.9	Дүүргийн авто замын гэрэлтүүлгийг сайжруулах, камержуулах ажлыг зохион байгуулах	ЗЦТ	Москвагийн гудамжны 300 ш, Үйлдвэрчний эвлэлийн гудамжны 200 ш, Зүүн салааны авто замын 156 ш гэрэлтүүлгийг эрчим хүчний хэмнэлттэй, дэвшилтэт технологи бүхий LED гэрлээр	70.0

				сольсон. Автозамын гэрэлтүүлгийн асалтын байдалд хийсэн шалгалтаар нийт 1249 гэрэлтүүлэгч байгаагаас асаж байгаа гэрэлтүүлэг 1137, нийт асалтын хувь 91% байна. Нийслэлийн Авто замын удирдлагын төвөөс ашиглалтыг хянадаг 1 камер Таван шарын уулзвар дээр байрлаж байна.	
214.		Шаардлагатай байршлуудад авто замын тэмдэг, тэмдэглэгээ, гэрэл дохиог шинээр суурилуулах	ЗЦТ	Дүүргийн нутаг дэвсгэрт шаардлагатай тэмдэг, гэрлэн дохио, хайс, хурд сааруулагчийн судалгааг гаргаж, 5 хурд сааруулагч, 20 анхааруулах тэмдэг, 20 мэдээлэх тэмдэг, бусад 145, нийт 190 ширхэг замын тэмдэг тэмдэглэгээг Орон нутгийн хөгжлийн сангийн 18.4 сая төгрөгөөр хийлгэв.	100.0
215.		Техник, хэрэгслийн хангамжийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх	ЗХХ	Замын цагдаагийн тасагт тоног төхөөрөмж, эд хогшил худалдан авахад 25.0 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас зарцуулав.	100.0
216.	5.10	Гамшгаас хамгаалах албад, Онцгой комиссын гишүүд, хороодын Засаг дарга нар, аж ахуйн нэгж байгууллагуудыг хамруулан штабын дадлага, гамшгийн эрсдлийг бууруулах, сургалт зохион байгуулах	ОБХ	Дүүргийн Онцгой комиссын бүрэлдэхүүн шинэчлэгдсэнтэй холбогдуулан дүүргийн Засаг даргын 131 дүгээр захирамжийн хэрэгжилтийн хүрээнд “Удирдах албан тушаалтны сургалт”-ыг онцгой комиссын 34 гишүүдийг хамруулан зохион явууллаа. Сургалтанд Улсын Онцгой комиссын үйл ажиллагааны талаар мэдээлэл хийж, “Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримталж буй бодлого, Онцгой комиссын ажиллах журам”, “Гамшгийн эрсдлийн үнэлгээ”, “Монгол орны болон Улаанбаатар хотын газар хөдлөлтийн нөхцөл байдал” сэдвүүдээр 6 цагийн танхимын сургалтыг явууллаа. Дүүргийн Засаг даргын 2013 оны 1/517 тоот албан бичгээр төрийн болон төрийн бус албан байгууллагуудад дадлага сургалт явуулах зааварчилгааг хүргүүлэн 2013 оны 03 дугаар сарын 28-ний өдрийн 16:00 цагт “Дуут дохио” дуугарснаар дадлага сургалтыг эхлүүллээ. Сургалтанд дүүргийн Засаг даргын Тамгын газар, дэргэдэх хэлтэс албад, ерөнхий боловсролын 19 сургууль, 32 цэцэрлэг болон төрийн болон төрийн бус 10 байгууллага, нийт 69 байгууллагын 3121 ажилтан албан хаагчид, 24387 оюутан, сурагчид, 27508 хүн хамрагдсан. Дүүргийн Цагдаагийн 1 дүгээр хэлтэс, Улаан загалмайн хороо, сайн дурын ажилчид сургалтад оролцогчдын аюулгүйн талбайд гарах ажиллагаанд хяналт тавьж ажилласан. Сургалтын үйл ажиллагааны талаар TV-5 телевиз, нийслэлийн Онцгой байдлын гарын вэб сайтаар сурталчлав.	100.0

217.		Хүн, мал, амьтан, ургамлын гоц халдварт өвчин, үерийн гамшгийн дараа бохирдсон зам талбай, хөрсийг ариутгах, халдваргүйжүүлэлт хийх зориулалт бүхий тоног төхөөрөмжтэй автомашинтай болох	ОБХ	Хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлэгдээгүй тул тасарсан	-
218.		Дүүргийн Онцгой комиссын хөдөлгөөнт удирдлагын автомашиныг тоноглох, тохижуулах	ОБХ	Хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлэгдээгүй тул тасарсан	-
219.	5.11	Хөдөлмөрийн аюулгүй байдалд тавих мэргэжлийн хяналт шалгалтыг хууль, тогтоомжийн хүрээнд явуулан, шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулж, болзошгүй үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.	МХХ	Газрын даргын баталсан “Барилга угсралтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудад хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу 35 барилгад хяналт хийж 89 зөрчил илрүүлж 31 зөрчлийг газар дээр нь арилгуулж аюулгүй ажиллагааны шаардлага хангахгүй ажиллаж байсан 6 барилгын үйл ажиллагааг түр зогсоож, 10 аж ахуйн нэгжид 53 заалттай 10 албан шаардлага хүргүүлж зөвлөгөө өгч ажиллалаа. Газрын дэд даргын баталсан 02-03/104 тоот “Хяналт шалгалтын тухай” удирдамжийн дагуу ноос ноолуур боловсруулах үйлдвэрлэл явуулдаг 6 аж ахуйн нэгжийн 25 нэгж объектод хяналт хийлээ. Шалгалтаар “Хөдөлмөрийн тухай хууль”, дүрэм заавар биелүүлээгүй 25 зөрчил, “Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хууль” , хөдөлмөр хамгааллын стандарт дүрэм журам зааврыг биелүүлээгүй 58 зөрчил, нийт 83 зөрчил илрүүлсний 58 зөрчлийг газар дээр нь арилгуулж, бусад зөрчлийг арилгуулахаар 25 заалттай 3 хамтарсан албан шаардлагыг “Хос гол” ХХК, “Капитал фактори” ХХК, “Буян холдинг” ХХК зэрэг аж ахуйн нэгж байгууллагад хүргүүлсэн. Мөн хөдөлмөрийн харилцааны талаархи эрхзүйн бичиг баримтыг хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулан мөрдөх талаар 6 аж ахуйн нэгж байгууллагад зөвлөгөө өгч, туслалцаа үзүүлэн ажилласан. Энэ хугацаанд иргэдээс 15 өргөдөл, утсаар 2 гомдол мэдээлэл, ААНБ-аас 30 албан бичиг, хүсэлт хүлээн авч, хуулийн хугацаанд зохих шийдвэрийг гарган, 13 ослын материал хүлээн авч, үйлдвэрлэлийн ослын акт тогтоон баталгаажуулж 18 аж ахуйн нэгжид тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны гэрчилгээ	100.0

				олголоо. 2013 оны эхний 9 сарын байдлаар хөдөлмөрийн аюулгүй байдлын 3 улсын байцаагч ажиллаж гаргасан зөрчилтэй нь холбогдуулан 11 байгууллагад 2.6 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч барагдууллаа.	
220.		Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагуудын хөдөлмөр аюулгүй ажиллагааны зохион байгуулалтын талаар хууль дүрмийн хүрээнд сургалт зохион байгуулах	МХХ	“Мун чулуу”, “Эх ачуут”, “Өсөх ордон” зэрэг 5 аж ахуйн нэгжид барилгын талбайд нь хөдөлмөрийн аюулгүй байдлын сургалт зохион байгуулж, мэргэжил аргазүйн туслалцаа үзүүлэв. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газраас зохион байгуулсан “Барилга дахь аюулгүй ажиллагаа” сургалтанд тус дүүрэгт барилга угсралтын үйл ажиллагаа явуулж буй 20 аж ахуйн нэгжийг хамруулж самбар, гарын авлагаар ханган ажиллав.	100.0
221.	5.12	Батлан хамгаалах хууль тогтоомжийг аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд сурталчлах, төрийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх	ЦШ	Дүүргийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилт, 18-50 насны эрэгтэйчүүдийн цэргийн үүргийн биелэлтийг шалган туслах ажлыг дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 12 аж ахуй нэгж, байгууллагад зохион байгуулж явуулсан. Энэхүү шалган туслах ажлаар нийт 360 цэргийн үүрэгтэн хамрагдаж, цэргийн тоо бүртгэлд хамрагдаагүй 15, цэрэг татлагаар ороогүй 26, цэргийн үүрэгтний үнэмлэхгүй 24, шилжилт хөдөлгөөн хийгдээгүй 20, цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах 46 иргэнийг тогтоон илэрсэн зөрчлийг арилган батлан хамгаалах хууль тогтоомжийг байгууллагын удирдлага, цэргийн үүрэгтнүүдэд тайлбарлан таниулах, гарын авлага тараах ажлыг зохион байгуулав. 2013 оны 3 дугаар сарын 14-ний өдөр Соёлын төв өргөөнд зохион байгуулагдсан “Бидний ажил” сэдэвт батлан хамгаалах хууль тогтоомж, нийслэл, дүүргүүдийн цэргийн штабуудын үйл ажиллагааг сурталчлах, иргэдэд ажлаа танилцуулах өдөрлөгийн арга хэмжээнд бэлтгэж оролцон давхардсан тоогоор 67 иргэнд шилжилт хөдөлгөөн хийсэн. Тус өдөрлөгийн арга хэмжээнд дүүргийн 32 хорооноос 160 ахмад дайчин, бэлтгэл офицер, ерөнхий боловсролын сургуулийн 120 сурагч оролцож, уулзалт цэнгүүний үйл ажиллагаа, батлан хамгаалах хууль тогтоомжийн танилцуулга, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабуудын үйл ажиллагаагаа сурталчилсан танилцуулга, Хүүхдийн ордны сурагчдын тоглолтыг үзүүлж, батлан хамгаалах төрийн үйлчилгээг иргэдэд	100.0

			хүргэсэн. Энхийг дэмжих ажиллагааны 10 жилийн ойд зориулсан “Монгол цэрэг-дэлхийн цэрэг” сэдэвт сургалт, сурталчилгааны ажлыг 2013оны 04 дүгээр сарын 26-ны өдөр Соёмбо кино театрт зохион байгуулсан. 300 орчим иргэд залуучуудыг хамруулж батлан хамгаалах хууль тогтоомжийг сурталчилсан. Дүүрэгт шилжин ирсэн 1053, шилжин явсан 616 иргэнийг хүлээн авч, хууль тогтоомж тайлбарлан таниулав.	
222.	Хүүхэд залуучуудад түүх соёл, үндэсний уламжлалаараа бахархах, цэрэг эх оронч үзэл төлөвшүүлэх, бие бялдрын хөгжлийг сайжруулах ажлыг зохион байгуулах	ЦШ	Нийслэлийн хэмжээнд зохион байгуулагдсан Цэргийн дүйцүүлэх албан хаагчдын тэмцээн 2013 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Батлан хамгаалах их сургуулийн байрлалд явагдаж тус дүүргийн дүйцүүлэх албан хаагчид тусгай байр эзэлсэн. Дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчдын дунд цэрэг спортын “Дөл” тоглолтыг 2013 оны 03 дугаар сарын 06-ны өдөр Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн байрлалд зохион байгуулж явуулав. Тус цэрэг спортын “Дөл” тоглолтод дүүргийн Ерөнхий боловсролын 13 сургуулийн 132 сурагч, багш дасгалжуулагчид хамрагдсан. Энэхүү арга хэмжээг NTB, ETV телевизүүд, дүүргийн вэбсайтад байршуулан мэдээлэл өгч, олон нийтэд сурталчиллаа. Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 92 жилийн ойг тохиолдуулан дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчдын дунд Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн үйл ажиллагааг сурталчлах “Бид эх орны ирээдүй” сэдэвт өдөрлөгийн ажиллагааг 2013 оны 03 дугаар сарын 13-нд Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн байрлалд зохион байгуулж явуулсан. Тус өдөрлөгөөр Батлан хамгаалах их сургуулийн түүхэн замнал сургалтын үйл ажиллагааны танилцуулга, сурагчдад цэрэг эх оронч хүмүүжил төлөвшил олгох лекц, Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн дайчин алдарын тасалгаа, цэргийн байр, жагсаалын үзүүлэх тоглолт, цэрэг дайчдын урлагийн тоглолт зэргийг дүүргийн ахлах ангийн 200 гаруй сурагчдад үзүүлж сурталчлах, эх оронч үзэл төлөвшүүлэх ажлыг зохион байгууллаа. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб, TV-9 телевизтэй хамтран нийслэлийн ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчдын дунд уралдаант танин мэдэхүйн АХА тэмцээнийг зохион байгуулж, Ирээдүй цогцолбор сургуулийн 11дүгээр ангийн сурагч Б.Баянбилэг тэргүүн байр эзлэн “Өргөмжлөл”, дурсгалын	100.0



				зүйлээр шагнагдсан. Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчдын дунд 2 үе шаттай зохиогдсон “Монгол цэргийн жавхаа” сэдэвт зохион бичлэгийн уралдаанд дүүргийн хэмжээнд эхний гурван байр эзэлсэн сурагчдын материалыг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабт хүргүүлж, оролцсон сурагчдад талархал хүртээсэн.	
223.		Дайчилгааны бэлэн байдлыг дээшлүүлж, албан тушаалтны сургалт, дадлагаар олгох мэдлэгийг нэмэгдүүлэх	ЦШ	Хорооны Засаг дарга нарын “Цэргийн бэлтгэл” сургалтыг 2013 оны 03 дугаар сарын 21-ний өдөр Батлан хамгаалах яамны хурлын танхимд, 2013 оны 03 дугаар сарын 22-нд Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн байрлалд зохион байгуулав. Цэргийн дүйцүүлэх албан хаагчдын сургалтыг дүүргийн Засаг даргын 2013 оны 229 дүгээр захирамжаар хөтөлбөр, төлөвлөгөө, оролцох бүрэлдэхүүн, шаардагдах зардлыг баталгаажуулан, Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн байрлалд 2013 оны 06 дугаар сарын 05-15-ныг хүртэл хугацаанд цэргийн анхан шатны болон үүрэг гүйцэтгэхэд шаардагдах мэдлэг, дадлага эзэмшүүлэх сургалтанд 8 дүйцүүлэх алба хаагчдыг хамруулан оролцуулав. Дүүргийн Засаг даргын 2013 оны 398 дугаар захирамжийн дагуу дүйцүүлэх албан хаагчдын гүйцэтгэх үүргийн мэдлэг дадлагын гүнзгийрүүлэх шатны сургалтыг Хил хамгаалах ерөнхий газрын 0164 дүгээр ангийн сургалтын баазийг түшиглэн цэргийн дүйцүүлэх албан хаагч 16 иргэнийг оролцуулж хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн. Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын 2013 оны Сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Орон нутгийн цэргийн отрядын удирдах бүрэлдэхүүнтэй явуулах сургалтыг 2013 оны 10 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулав.	100.0
224.		ЗДТГ-ын хэмжээнд мэдээллийн аюулгүй байдлыг хангах талаар журам боловсруулж, хэрэгжилтийг хангуулах талаар албан тушаалтнуудтай хамтран ажиллах	ЦШ	Засаг даргын Тамгын газрын мэдээллийн аюулгүй байдал, нууцыг хамгаалах, дотоод сүлжээнд ажиллах журмыг боловсруулан холбогдох албан тушаалтануудад хянуулан Засаг даргын захирамжаар баталгаажуулсан.	100.0
225.	5.13	Монголд үйл ажиллагаа явуулж байгаа Олон улсын байгууллагуудтай хамтарч ажиллан, тодорхой төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх	ЗХХ	2013 оны 2 дугаар сард БНСУ-ын “Эмч нарын сайн дурын сан” ТББ-тай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурсан. Хамтын ажиллагааны хүрээнд 9 дүгээр сард БНСУ-ын шүдний эмч нарын баг Монголд ирж дүүргийн иргэдэд эмнэлгийн үйлчилгээ үнэ төлбөргүй үзүүлсэн. 2013 оны 5 дугаар сараас БНСУ-ын	90.0

			<p>Байгаль орчны сан, Монголын “Хөгжил дэх оролцооны төлөө холбоо-Жи Си Эс” ТББ хамтран Солонгосын “Лотте” группийн дэмжлэгтэйгээр дүүргийн цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй өрхүүдэд нарны үүсгүүрт гэрэл олгох “Хүжийн гал” төслийг хэрэгжүүлж эхлээд байна. Тус төслийн хүрээнд 135ш нарны үүсгүүрт гэрлийг амьжиргааны түвшин доогуур, цахилгаан эрчим хүчгүй, сургуулийн насны олон хүүхэдтэй айлуудад олгосон. “Дэлхийн зөн” ОУБ-тай хамтран Толгойт, Баянхошуу бүсийн хороодоос 4 хороог сонгож 700 өрхийн амжиргааг дээшлүүлэх, тэднийг мэргэжлийн сургалтад хамруулан нийгмийн асуудлыг нь цогц хэлбэрээр шийдэх, байнгын ажлын байртай болгох зорилгоор “Төгсөлтийн аргачлал” төслийг хэрэгжүүлж эхлэхээр Дүүргийн Засаг даргын захирамж гарган, ажлын хэсэг байгуулахаар ажиллаж байна. Мөн “Дэлхийн зөн” ОУБ-тай хамтран “Боловсрол”, “Эрүүл мэнд”, “Эдийн засаг”, “Хүүхэд хамгаалал” зэрэг төслүүдийг хэрэгжүүлж байна. Дэлхийн банкны санхүүжилтээр дүүргийн 18, 21, 32 дугаар хороодод тус бүр 100 хүүхдийн ортой цэцэрлэг барих төслийг хэрэгжүүлж байна. 2013-2016 онд хэрэгжих энэхүү төслийг хэрэгжүүлэхээр Дэлхийн банктай хамтран ажиллах гэрээ байгуулсан. Одоо зураг төслийн тендер зарлах шатандаа уг ажил явагдаж байна. Азийн хөгжлийн банктай хамтран олон улсын стандартад нийцсэн жишиг Нэгдсэн эмнэлэг барих төслийг хэрэгжүүлж байна. Уг эмнэлэг баригдах нийт төсөв нь 25.0 сая доллар бөгөөд одоо зураг төслийн ажил хийгдэж байна.</p>	
226.	Гадаадын хөрөнгө оруулагч нартай хамтран ажиллах боломжийг судлах, хамтын ажиллагаатай гадаадын хот, дүүргүүдтэй үйл ажиллагаагаа өргөжүүлэх	ЗХХ	<p>Хамтын ажиллагаатай БНСУ-ын Сөүл хотын Сеонбуг дүүргийн Засаг даргын урилгаар энэ оны 5 дугаар сард дүүргийн Засаг даргын орлогчоор ахлуулсан төлөөлөгчид ажлын айлчлал хийгээд ирсэн. Энэ айлчлалаар хоёр дүүргийн хамтын ажиллагааг өргөжүүлэх бодитой ажлууд хийх, хөрөнгө оруулалтын чиглэлээр хамтарч ажиллахаар санал тавьж харилцан тохиролцсон. Хамтын ажиллагаатай БНХАУ-ын Хөлөнбуйр аймгийн Хайлаар хотод 6 дугаар сард болсон Хятад, Монгол, Орос гурван улсын Эдийн засгийн форум, Үзэсгэлэн худалдаанд оролцлоо. Дүүргээс тус үйл ажиллагааны Эдийн засгийн форумд Засаг даргын орлогч Ц.Төрхүү илтгэл тавьж, Үзэсгэлэн худалдаанд аж ахуйн нэгжүүдээ</p>	90.0

				<p>зохион байгуулж оролцуулсан. Дүүргийн нутаг дэвсгэр 361-ийн гарам орчим “Аж үйлдвэрийн парк” байгуулахад хөрөнгө оруулалт хүссэн Засаг даргын 2013 оны 1/1187 албан бичгийг 7 дугаар сард БНСУ-ын “Леадинг аллиансе” ХХК-д илгээсэн бөгөөд тус компанийн зүгээс хөрөнгө оруулалт хийж хамтран ажиллахаа илэрхийлсэн. 7 дугаар сарын 22-27-ны өдрүүдэд хамтын ажиллагаатай БНСУ-ын Сөүл хотын Сеонбуг дүүргийн Засаг даргын орлогч Ким Бёонг Хван тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авсан. Энэ айлчлалын үеэр дүүргийн зүгээс Үйлдвэрчний эвлэлийн 2.8 км урт гудамжийг хамтран тохижуулах санал тавьж Санамж бичгийн төслийг Сеонбуг дүүргийн Засаг даргын орлогчид гардуулсан. 9 дүгээр сард дүүргийн ЗДТГ-ын Захиргаа хуулийн хэлтсийн даргаар ахлуулсан төр, захиргааны байгууллагын төлөөлөл 22 албан хаагч БНХАУ-ын Хайлаар хотод туршлага судлах аялалд хамрагдсан. 2013 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр БНСУ-ын Тэжон хотын Со дүүргийн ИТХ-ын дарга Ко Кунг Кеун тэргүүтэй 7 төлөөлөгч айлчлал хийсэн. 2013 оны 11 дүгээр сарын 19-25-ны өдрүүдэд БНСУ-ын Тэжон хотын Со дүүргийн урилгаар дүүргийн Засаг даргын Тамгын газрын болон дэргэдэх хэлтэс албадын зарим дарга нарын бүрэлдэхүүнтэй удирдлагын баг Со дүүргийн нутгийн захиргааны байгууллагууд, шуурхай удирдлагын төвүүдтэй танилцах, туршлага судлах аяллыг зохион байгууллаа.</p>	
227.		Хөгжингүй орны хот, дүүргүүдтэй шинээр хамтын ажиллагаа тогтоох талаар судалгаа хийж, санал тавьж хамтарч ажиллах	ЗХХ	<p>БНСУ-ын Тэжон хотын Со дүүрэгт хамтран ажиллах санал тавьсан бөгөөд тус дүүргээс энэ оны 8 дугаар сард дүүрэгт айлчлан ирж хамтын ажиллагааны гэрээ байгуулахаар болсон. “Монголын хотуудын холбоо”-той хамтран АНУ-ын Өмнөд Дакота мужын Бриттон, Техас мужын Фриско хот, Европын өндөр хөгжилтэй орнуудын хот дүүргүүдтэй хамтран ажиллах боломжийг судлан ажиллаж байна. Засаг дарга М.Чинболд Япон улсын Цукуба хотод үйл ажиллагаа явуулдаг “Takaragi Japan” ХХК-ийн зөвлөх Нишизава Такэшигэг хүлээн авч уулзаж Цукуба хоттой хамтран ажиллах санал тавьж санамж бичгийн төслийг хүргүүлсэн.</p>	90.0
228.	5.14	Дүүргийн нутаг дэвсгэрт Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах ажлыг зохион байгуулах	ЗХХ, ХЭАХН	<p>Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн А/95 дугаар тогтоолоор Хэрэглэгчийн эрхийг хамгаалах талаар 2013 онд дүүрэгт зохион байгуулах ажлын төлөвлөгөөг 22 заалттайгаар</p>	90.0

			<p>батлуулан хэрэгжилтийг зохион байгуулав. Дүүргийн Хэрэглэгчийн эрхийг хамгаалах ажилтай холбогдуулан 11-р сарын 30-ны байдлаар 4042,5 мян төгрөгний санхүүжилт өгч, ХЭАХН-ийн ажлын өрөөг 18-р хорооны хуучин байранд 2013 оны 4-р сараас эхлэн шинээр тохижуулан ашиглаж байна. Хэрэглэгчийн эрх хамгаалах ажлын эрчимжүүлэх тухай Засгийн газрын 2013 оны 2/82 албан даалгаврыг аж ахуйн нэгж, байгууллагуудад мөрдүүлэх ажлыг зохион байгуулж байна. Хэрэглэгчийн эрх зөрчигдсөн тухай бичгээр 6, утсаар 43 гомдлуудыг хүлээн авч хуулийн хугацаанд нь шалган шийдвэрлэж, 20 гаруй байгууллагаар хяналт шалгалт хийж гомдлыг барагдуулж 25 төрлийн 98 хуудас албан бичиг материалуудыг боловсруулан бусад байгууллагуудад явуулсан. Хэрэглэгчийн эрх хамгаалах ажлын эрчимжүүлэх тухай Засгийн газрын 2013 оны 2/82 албан даалгаврыг аж ахуйн нэгж, байгууллагуудад мөрдүүлэх ажлыг зохион байгуулж байна.</p>	
--	--	--	--	--

---000---

